



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization

UNESCO
INSTITUTE
for
STATISTICS



ЮНЕСКО-ГИЙН 2009 ОНЫ СОЁЛЫН СТАТИСТИКИЙН ХҮРЭЭ

ЮНЕСКО-гийн 2009 оны соёлын статистикийн хүрээ

ЮНЕСКО

Нэгдсэн үндэсний байгууллагын боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (юнеско) байгуулах шийдвэрийг 1945 оны 11 дүгээр сард Лондонгийн бага хурал дээр 20 орон санал нэгтгэй баталжээ. Энэхүү шийдвэр нь 1946 оны дөрөвдүгээр сарын 04 нд хүчин төгөлдөр болсон аж. Одоо тус байгууллагад 193 гишүүн орон, холбооны 7 гишүүн орон багтдаг.

ЮНЕСКО-гийн гол зорилго нь дэлхий ертөнц дээр боловсрол, шинжлэх ухаан, соёл, харилцаагаар дамжуулан нийтээр бие биенээ хүндэтгэх, шударга ёсыг тогтоох тухай НҮБ-аас баталсан дүрмийн дагуу арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэгийг ялгалгүй хүний эрх, үндсэн эрхийг хамгаалахад оршино.

ЮНЕСКО нь бүрэн эрхээ амьдралд хэрэгжүүлэхийн тулд дараах үндсэн 5 үүргийг гүйцэтгэдэг. Үүнд: 1) дэлхий ертөнцийн ирээдүйн тулд боловсрол, шинжлэх ухаан, соёл болон харилцааны салбарт ирээдүйтэй судалгааг явуулах; 2) туршилт, бэлтгэл сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны замаар мэдлэгийг хөгжүүлэн, дамжуулан түгээн дэлгэрүүлэх; 3) дотоод арга хэрэгсэл, хэм хэмжээний удирдамжаа бэлтгэх, нэвтрүүлэх стандартаа тодорхойлох; 4) гишүүн орнуудын техникийн хамтын ажиллагаанд түшиглэн тэдний улс төр, хөгжлийн төслийг шинжлэн судлах; 5) салбаруудын хоорондын мэдээллүүдийг солилцох ажлыг хэрэгжүүлэх зэрэг болно.

ЮНЕСКО-гийн удирдлага Францын Парис хотод байрладаг.

ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэн (ЮОХ)

Статистикийн хүрээлэн нь ЮНЕСКО-гийн статистикийн салбар бөгөөд НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, технологи, соёл болон харилцаа зэрэг салбаруудыг нэгтгэсэн дэлхийн статистик мэдээллийн сан юм.

Энэхүү хүрээлэн нь 1999 онд байгуулагдсан. ЮНЕСКО-гийн статистик программыг хэрэгжүүлэх, түүнчлэн улам бүр нарийн түвэгтэй хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа улс төр, нийгэм соёл, эдийн засгийн нөхцөл байдалд хэрэгцээтэй, улс төрийн ач холбогдолтой чухал тоо баримтыг цаг тухай бүрт нь түгээн дэлгэрүүлэх статистик хөтөлбөрийг боловсронгуй болгоход зориулагдсан.

ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэн нь Канадын Монреалд байрладаг.

Хэвлэсэн он 2010

ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэн
ш/х 6128, Succursale Centre- Ville
Монреал, Quebec H3C 3J7
Канад

Тел: (1 514) 343-6880
Факс: (1514) 343-5740
Е-мэйл: publications@uis.unesco.org
<http://www.uis.unesco.org>

ISBN 978-92-9189-075-0
Ref: UIS/TD/09-03/REV

©UNESCO-UIS 2009

Өмнөтгөл

ЮНЕСКО-гийн 2009 оны соёлын статистикийн хүрээ нь статистикийн хүрээлэн, ЮНЕСКО-гийн соёлын салбарын хамтын хүчин зүтгэлийн үр дүн юм. ЮНЕСКО-гийн соёлын статистикийн арга хэлбэр нь 1986 оноос хойш соёлын салбарт гарсан шинэ үзэл санаануудыг харгалзан үзсэн уг шинэчлэгдсэн хувилбар болох ЮНЕСКО-гийн 1986 оны соёлын статистикийн хүрээнд тулгуурласан бөгөөд үүнд соёл болон соёлын хэрэглээний арга замуудыг үндсээр нь өөрчилсөн шинэ арга технологиудтай холбоотой биет бус соёлын өв, соёлын практик, бодлогын хөгжил багтана.

Соёл нь дэлхий ертөнцийн бүхий л нийгмийн харилцаанд голлох үүрэг гүйцэтгэн хүмүүсийн чөлөөт цаг заваас эхлээд мэргэжлийн үйл ажиллагааны бүхий л хүрээнд нөлөөлдөг. Хөгжлийн үйл явцад соёлын гүйцэтгэх үүрэг нь сүүлийн үед бодлогын чухал асуудал болсон ч соёл тус бүрийн өвөрмөц шинжийг хүндэлж, хадгалж, бусад соёлуудын өвөрмөц шинж чанарыг өргөн хэмжээгээр зохицуулах асуудал дэлхийн хэмжээнд тулгараад байна.

Баримтад тулгуурласан бодлогуудыг томъёолж, тэдгээрийн нөлөөг хэмжиж, үнэлж дүгнэхэд бодит мэдээлэл зайлшгүй шаардлагатай. Соёлын албан ёсны, тогтсон ойлголтод тулгуурлаж 1986 оныг хүртэл мөрдөж ирсэн соёлын статистикийн хүрээ нь хөгжиж буй орнуудын өнөөгийн илүү өргөн хүрээтэй чиг баримжаа, хандлагыг тусгаж чадахгүй байсан тул ЮНЕСКО-гийн зүгээс шинэчлэх шаардлагатай гэж үзсэн. Түүнчлэн уг шинэ хамрах хүрээ нь соёлын статистикийн олон улсын хэмжээний харьцуулалтын бүтээмж, түгээн дэлгэрүүлэлтийг хэрэгжүүлэх боломжтой болгох үзэл баримтлалын үндэс суурь, арга замыг бий болгоно.

Дэлхийн хэмжээнд 4 жилийн турш иж бүрэн судалж зөвлөлдсөний үр дүнд уг хянаж шинэчилсэн хувилбарыг боловсрууллаа. Уг арга зүйг боловсруулахад олон тооны эрдэмтэн, мэргэжилтэн, статистикчид, ЮНЕСКО-гийн гишүүн орнууд, олон улсын байгууллагууд оролцож тус тусын хувь нэмрээ оруулсан. Соёл болон соёлын статистикийн судалгаанд өргөн хүрээтэй шинэ ирээдүйг нээсэн энэ арга зүйг боловсруулахад оролцсон харилцан адилгүй оролцогчдын янз бүрийн, олон талын хувь нэмрийг үнэлж баршгүй юм. 2009 оны соёлын статистикийн хүрээг олон улсын болон, үндэсний хэмжээнд ашиглах арга зүй болгон боловсруулжээ. Уг соёлын статистикийн хүрээний үндсэн зорилго нь соёлын нэгдсэн ойлголтоор дамжуулж олон улсын харьцуулалт хийж, стандарт тодорхойлолт болон олон улсын нийгэм эдийн засгийн ангиллыг ашиглахад оршино.

ЮНЕСКО уг төслөөр дамжуулж соёлын статистикийн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжинэ гэж найдаж байгаа. Соёлын хөтөлбөр, бодлогын хамаарал, тэдгээрийн нөлөөллийг илүү сайн хэмжиж тодорхойлоход гишүүн орнууд, олон улсын агентлаг болон төрийн бус байгууллагуудад баримт, статистик мэдээ онцгой их шаардагддаг. Соёлын нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг илүү сайжруулсан байдлаар хэмжих үйлст 2009 оны соёлын статистикийн хүрээ хувь нэмрээ оруулна гэдэгт бид итгэж байна.



Хендрик ван дер Пол
ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнгийн
захирал



Франсуа Ривьер
ЮНЕСКО-гийн Соёлын салбарын Ерөнхий
захирлын туслах

Талархал

ЮНЕСКО-гийн 2009 оны соёлын статистикийн хүрээ төслийг ЮНЕСКО-гийн статистик хүрээлэнгийн мэргэжилтэн Хосе Пессоа, Лидия Делумо нар Саймон Эллисийн ерөнхий удирдлага дор боловсруулсан. Уг хамрах хүрээ нь Ричард Нэйлор (Би-О-Пи Консалтинг), Энди Пратт (Лондоны эдийн засгийн сургууль), Кэлвин Тэйлор (Лийдсын их сургууль) нарын бүрэлдэхүүнтэй зөвлөх багийн статистикийн хүрээлэнд зориулж боловсруулсан эхний тайланд тулгуурласан.

Соёлын статистикийн хүрээг боловсруулж гаргахын тулд соёлын статистик, бодлогын салбарын олон эрдэмтэн, статистикч, шинжээч нардэлхийн хэмжээнд зөвлөлдсөн бөгөөд эдгээрт олон соёлын яамдын төлөөлөгч, үндэсний статистикийн алба, олон улсын хамтрагч агентлагууд багтана. Иймээс ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэн уг соёлын статистикийн хүрээг боловсруулах, бэлтгэх ажилд хувь нэмрээ оруулсан ЮНЕСКО-гийн соёлын салбарын мэргэжил нэгтнүүддээ талархал илэрхийлж байна.

Статистикийн хүрээлэнгийн зүгээс удирдамж, мэргэжлийн зөвлөгөө өгсөн ажлын хэсгийн дараах гишүүдэд онцгой талархал илэрхийлж байна: Альфонсо Кастельянос-Рибо (ахлагч) Гуёмар Алонсо Кано, Марта Бек-Домзальска, Хелен Бейлби-Оррин, Владимир Бина, Ибтиссам Эль Жоуни, Мате Ковач, Гленн Масокоане, Лилиана Ортиз-Оспино, Ж.П.Сингх, Дэвид Тросби.

ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэнгийн зүгээс Монгол улсын Соёл, Урлагийн Их Сургуулийн (СУИС) соёлын статистикийн төслийн багт уг албан ёсны орчуулгыг хийлгэсэнд талархал илэрхийлж байна. Уг ажлыг Монгол улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам (БСШУЯ) санхүүжүүлсэн юм.

Товчилсон үгс

АШЗМСА	Австрали, Шинэ Зеландын мэргэжлийн стандарт ангилал Australian and New Zealand Standard Classification of Occupation (ANZSCO)
АШЗУСА	Австралийская и новозеландская стандартная классификация занятости АНСКЗ Австрали, Шинэ Зеландын үйлдвэрлэлийн стандарт ангилал Australian and New Zealand Standard Industrial Classification (ANZSIC)
БХОТЭЗХАБ	Австралийская и новозеландская стандартная промышленная классификация АНСПК Бенгалын хойгийн орнуудын олон салбарын техник, эдийн засгийн хамтынажиллагааны байгууллага Bay of Bengal Initiative for Multi-Sectoral Technical and Economic Cooperation BIMSTEC Организация стран Бенгальского залива в сферах экономического и
ТТ	технического взаимодействия ОСБЗЭТВ Төлбөрийн тэнцэл Balance of Payments BOP Платежный баланс ПБ
ЗГҮА	Засгийн газрын үүргийн ангилал Classification of the Functions of Government COFOG
ХЗХБҮА	Классификация функций органов управления КФОУ Хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангилал Classification of Individual Consumption by Purpose COICOP
АББЗА	Классификатор индивидуального потребления домашних хозяйств по целям КИПЦ-ДХ Ашгийн бус байгууллагуудын зорилгын ангилал Classification of the Purposes of Non-profit Institutions COPNI
БҮАА	Классификация целей некоммерческих организаций КЦНО Бүтээгдэхүүний үйл ажиллагааны ангилал, Европ Classification of Products by Activity, EU CPA
БҮНА	Классификатор продукции по видам деятельности, ЕС КПВД Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал Central Product Classification CPC
ХҮ	Классификация основных продуктов КОП Хамтралын үйлчилгээ Collective Services CS
DCMS	Коллективные услуги КУ Соёлын тэнхим, ОУСХ болон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын спортын хэвлэл мэдээллийн хэрэгсэл Department of Culture, Media and Sport, United Kingdom DCMS
ТТҮА	Департамент культуры, СМИ и спорта Соединенного Королевства DCMS Төлбөрийн тэнцэл дэх үйлчилгээний ангилал Extended Balance of Payments Services Classification EBOPS
ССХ	Расширенная классификация услуг в платежном балансе EBOPS ЮНЕСКО-гийн соёлын статистикийн хүрээ UNESCO Framework for Cultural Statistics FCS
ЦАСҮАОУА	Система статистики культуры ССК НҮБ-ын төсөл – цаг ашиглалтын судалгааны үйл ажиллагааны олон улсын ангилал UN Trial – International Classification of Activities for Time-Use Statistics ICATUS
ББСӨ	Проект ООН – Международная классификация деятельности По статистикеи спользуемого врем, ICATUS Биет бус соёлын өв Intangible Cultural Heritage ICH
МХТ	Нематериальное культурное наследие НКН Мэдээлэл харилцааны технологи Information and Communication Technologies ICT Информационно-коммуникационные технологии ИКТ

ОУБХӨУАТФ	Олон улсын биологийн хувьд өөр өөр уугуул ард түмнүүдийн форум International Indigenous Forum on Biodiversity IIFB
ОУХБ	Международный форум коренных народов по биологическому разнообразию IIFB Олон улсын хөдөлмөрийн байгууллага International Labour Organization ILO
ХХУ	Международная организация труда МОТ Хувь хүний үйлчилгээ Individual Services IS
БОУСА	Индивидуальные услуги ИУ Боловсролын олон улсын стандарт ангилал International Standard Classification of Education ISCED
АМОУСА	Международная стандартная классификация образования МСКО Ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал International Standard Classification of Occupations ISCO
ЭЗБТУАСА	Международная стандартная классификация занятий МСКЗ Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал International Standard Industrial Classification ISIC
EU.LEG	Международная стандартная отраслевая классификация МСОК Соёлын статистикийн Европын холбооны тэргүүлэх зэрэглэлийн шинжээчдийн баг European Union Leadership Expert Group on Cultural Statistics LEG
МХЗ	Экспертная группа руководства ЕС по статистике культуры ЭГЛ Мянганы хөгжлийн зорилтууд, НҮБ Millennium Development Goals, United Nations MDG
ҮСХ	Цели развития тысячелетия, ООН ЦРТ Үндэсний статистикийн хороо National Statistical Office NSO
ЭЗХАХБ	Национальное статистическое управление НСУ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага Organisation for Economic Co-operation and Development OECD
ЕХОЭЗҮАА	Организация экономического сотрудничества и развития ОЭСР Европын холбооны орнуудын эдийн засгийн үйл ажиллагааны ангилал Classification of Economic Activities in the European Community NACE
ҮАХАС	Классификация видов экономической деятельности Европейского Сообщества КДЕС Үйлдвэрлэлийн ангиллын Хойд Америкийн систем North American Industry Classification System NAICS
БАХАС	Североамериканская система классификации отраслей NAICS Бүтээгдэхүүний ангиллын Хойд Америкийн систем North American Product Classification System NAPCS
АХДСШН	Североамериканская система классификации продуктов NAPCS Африкийн хөгжлийг дэмжих сонирхолтой шинэ нөхөрлөл New Partnership for Africa's Development NEPAD
ҮСА	Новое партнерство в интересах развития Африки НЕПАД Үйлдвэрлэлийн стандарт ангилал Standard Industrial Classification SIC
ОУХСА	Стандартная промышленная классификация СП Олон улсын худалдааны стандарт ангилал Standard International Trade Classification, Revision 4, SITC 4
ҮТС	Стандартная классификация международной торговли, версия СКМТ 4 Үндэсний тооцооны систем System of National Accounts SNA
АЖСТ	Система национальных счетов СНС Аялал жуулчлалын дагалдах тайлан Tourism Satellite Account, TSA
ЮНЕСКО –н СХ	Сателлитный отчет по туризму ТСС ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэн UNESCO Institute for Statistics UIS Институт статистики ЮНЕСКО ИСЮ

НҮБ. ХХХ	НҮБ – ын худалдаа, хөгжлийн хөтөлбөр United Nations Conference on Trade and Development UNCTAD Конференция ООН по торговле и развитию ЮНКТАД
НҮБ, УАТАЭБН	НҮБ-ын уугуул ард түмний асуудал эрхэлсэн байнгын нийгэмлэг United Nations Permanent Forum on Indigenous Issues UNPFII Постоянный форум ООН по вопросам коренных народов UNPFII
НҮБ, СХ	НҮБ – ын статистикийн хэлтэс United Nations Statistics Division UNSD Статистический отдел ООН СООН
ДАЖБ	Дэлхийн аялал жуулчлалын байгууллага World Tourism Organization UN WTO Всемирная организация по туризму ВОТ
ОУОӨБ	Олон улсын оюуны өмчийн байгууллага World Intellectual Property Organization WIPO Всемирная организация интеллектуальной собственности ВОИС
ОУХБ	Дэлхийн худалдааны байгууллага World Trade Organization WTO Всемирная торговая организация ВТО
n.s.e.	Өөр хаана ч тэмдэглээгүй Not elsewhere specified Не указано в другом месте
n.e.c.	Өөр хаана ч ангилаагүй Not elsewhere classified Не классифицировано в других рубриках
n.f.d.	Тодорхойлолт бүрэн бус Not fully defined Определение дано не полностью

Агуулга

Өмнөтгөл	i
Талархал	iv
Товчилсон үгс	v
Товч агуулга.....	9
1. Удиртгал.....	11
1.1 Үндэслэл	11
1.2 Соёлын статистикийн хүрээг өөрчлөх болсон бодлогын нөхцлүүд	13
1.3 Соёлын статистикийн хүрээг дахин хянаж шинэчлэх ажиллагааны зорилго, үндсэн зорилтууд	16
2. Соёлын статистикийн хүрээ: Үзэл баримтлал ба бүтэц	17
2.1 Соёлын статистикийн хүрээний хянан шинэчлэлт: Шинэ хандлага.....	17
2.2 Соёлыг статистикийн зорилгоор тодорхойлох нь	18
2.3 Соёлын мөчлөг	19
2.4 Соёлын салбарын хамрах хүрээ.....	22
2.5 “Соёлын салбарууд”-ыг тодорхойлох нь	22
3. Соёлын статистик: Эдийн засгийн үзүүлэлтийг хэмжих нь	33
3.1 Соёлын эдийн засгийн үзүүлэлтийн хэмжилтэд олон улсын ангиллыг хэрэглэх нь	33
3.2 Соёлын бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тодорхойлох нь: Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал (БҮНА) болон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллыг (ЭЗБТУАСА) ашиглах нь	35
3.3 Олон улсын соёлын худалдаа: Уялдуулсан систем (УС) болон Төлбөрийн тэнцлийн үйлчилгээний ангиллыг (ТТҮА) ашиглах нь	37
3.4 Соёлын салбар дахь ажил эрхлэлт: Ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал (АМОУСА)-ыг ашиглах нь	39
3.5 Соёлын өвийг хэмжих нь	43
4. Соёлын статистик: Нийгмийн үзүүлэлтүүдийг хэмжих нь.....	44
4.1 Соёлын оролцоог хэмжих нь	44
4.2 Биет бус соёлын өвийг хэмжих нь.....	46
5. Тоо баримт цуглуулах: Олон улсын ангиллын дүрмийн хүснэгтүүд	51
Хүснэгт 2. БҮНА 2, ЭЗБТУАСА 4 ангиллуудаар тодорхойлогдсон соёлын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бараа, үйлчилгээ	52
Хүснэгт 3. 2007 оны уялдуулсан системийн (УС) ангиллаар тодорхойлогддог соёлын бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улсын худалдаа	65
Хүснэгт 4. АМОУСА 08 ангиллаар тодорхойлогдсон соёлын салбарын ажил мэргэжлүүд	75
Хүснэгт 5. ЦАСҮАОУА-ыг ашигласан цаг ашиглалтын судалгаа.....	80
6.Дүгнэлт.....	85
6.1. Соёлын тоо баримт цуглуулахад гарч буй хүндрэлүүд	85
6.2. Шууд хэмжилттэй холбох нь	87
Тайлбар толь.....	89
Ном зүй.....	95

Товч агуулга

ЮНЕСКО-гийн 2009 оны соёлын статистикийн хүрээний (ССХ) зорилго

ССХ нь соёлын статистикийг үндэсний болон олон улсын хэмжээнд зохион байгуулах арга хэрэгсэл юм. Энэ систем нь соёлын илрэлийн өргөн хүрээг түүний бүтээж буй нийгэм эдийн засгийн аргаас үл шалтгаалан хэмжих боломж олгодог бөгөөд соёлын тухай түгээмэл болоод нийтээр хүлээн зөвшөөрдөг суурь ойлголтод тулгуурласан. Түүнчлэн стандарт тодорхойлолтыг ашигласнаар олон улсын хэмжээнд харьцуулах боломжтой тоо баримт бий болгох боломж олгодог.

Уг хамрах хүрээ нь 1986 оны ССХ-нд (ЮНЕСКО, 1986) тулгуурлан бий болж, улмаар даяарчлалын эрин үед соёлын бүтээгдэхүүнийг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэхэд нөлөөлөх, ингэхдээ орчин үеийн практик, оюуны өмчийн асуудлыг тусгасан удаа дараагийн хэлэлцүүлгийн үр дүнд дахин боловсруулагдсан юм.

Соёлын эдийн засгийн үзүүлэлт, хэмжилтийг хөгжүүлэх үндсэн нөхцөл нь эдийн засгийн тоо баримт болон олон улсын ангиллын системүүд оршиж буйгаас шалтгаалах бөгөөд соёлд орших нийгмийн шалгууруудын ач холбогдол нь соёлын оролцоо болон биет бус соёлын өвийг тэгш оролцуулснаар тодорхойлогдоно. Хэдий тэдгээрийг хэмжих эхний элементүүдийг төлөвлөсөн ч цаашид энэ чиглэлээр ажиллах шаардлагатай.

Соёлын статистикийн хүрээ гэдэг нь эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллыг (ЭЗБТҮАСА) соёлын үйлдвэрлэлтэй холбоотой үйл ажиллагаанд, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангиллыг (БҮНА) соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээнд, ажил мэргэжлийн олон улсын стандарт ангиллыг (АМОУСА) соёлын ажил эрхлэлтийн чиглэлээр тал бүрээс нь тодотгох уялдаат систем (УС) ба бүтээгдэхүүний кодчиллыг соёлын бүтээгдэхүүний олон улсын эргэлтийн чиглэлд, НҮБ-ын төсөл болох цаг ашиглалтын судалгааны үйл ажиллагааны олон улсын ангиллыг (ҮАЗЦАОУСА) соёлын оролцоог хэмжихэд тус тус ашиглах зэргээр одоогоор ашиглагдаж буй олон улсын ангиллын системүүдийг ашигласан ангиллын арга хэрэгсэл юм. Үүний үр дүн нь олон улсын болоод үндэсний хэмжээнд соёлын салбарт гарч буй тоо баримтыг цуглуулах, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх үндсэн арга хэрэгсэл болж байна. Түүнчлэн соёлын бүтээмж, хуваарилалт, ашиглалттай холбоотой соёлын үйл ажиллагааны өргөн хүрээг хамруулан тусгахыг эрмэлзсэн болно.

Соёлыг тодорхойлох нь

ЮНЕСКО-гоос соёл гэдэг нь нийгэм болон нийгмийн хэсэг бүлгийн оюун санаа, материаллаг байдал, мэдлэг оюун, сэтгэл санааны шинж байдлын цогц бөгөөд зөвхөн урлаг, утга зохиол төдийгүй амьдралын хэв маяг, хамтын амьдралын арга зам, үнэ цэнэтэй систем, уламжлал, итгэл үнэмшлийг хамарна гэж тодорхойлжээ (ЮНЕСКО, 2001). Итгэл үнэмшил, үнэт зүйлсийн заримыг хэмжих боломжгүй ч эдгээртэй холбоотой зан үйл, дадлыг хэмжиж болдог. ЮНЕСКО-гийн соёлын статистикийн хүрээ нь нийгэм буюу нийгмийн бүлгийн итгэл үнэмшил, үнэт зүйлсээр тодорхойлогддог зан үйл, дадлыг илрүүлж, хэмжиж тодорхойлдог.

Соёлын статистикийн хүрээнд онцолсноор *соёлын салбарууд нь* эдийн засаг (бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл гэх зэрэг) болон нийгмийн (соёлын үйл ажиллагаанд оролцох гэх зэрэг) үйл ажиллагааны ерөнхий цогц бөгөөд үүнийг уламжлалын дагуу “соёлын” хэмээн авч үздэг. Түүнчлэн *холбогдох салбаруудад* “зарим талаараа соёлын” буюу “үзвэр, үйлчилгээ” гэж үзэж болох “дан соёлын” гэж ангилж боломгүй эдийн засаг, нийгмийн бусад үйл ажиллагаануудыг хамруулсан.

Эдгээр тодорхойлолтуудын ихэнхийг боловсруулахад ашиглаж байгаа одоо мөрдөж буй стандартууд нь эдийн засгийн үзэл баримтлалд тулгуурласан ч үүний үр дүнд үүсэх салбар нь соёлын дан ганц эдийн засгийн хандлагад хамаардаггүй бөгөөд тухайн салбарын бүхий л хүрээг хамаардаг. Тэгэхээр “тоглолт” гэдгийг хэмжиж тодорхойлбол мэргэжлийн эсвэл сонирхогчийн, концертын албан ёсны зааланд эсхүл хөдөө орон нутагт ил задгай талбайд тоглогдож байгаагаас үл хамааран бүх тоглолтууд багтана.

Түүнчлэн уг хүрээнд секторын хэсгүүдийг бүхэлд нь хамарч хэмжигдэх “*нийтлэг хамааралтай*” гэгдэх гурван салбарыг тодорхойлсон. *Боловсрол ба сургалт, архивлах ба хадгалах, биет бус соёлын өв* зэрэг нь нийтлэг хамааралтай салбарууд гэж ангилагдах бөгөөд соёлын бүтээлч үйл ажиллагааг бүрэн дүүрэн хэмжиж тодорхойлоход энэ гурван салбар онцгой чухал ач холбогдолтой.

Соёлыг хэмжих тухай: Прагматик аргачлал

Улс орнуудын соёлын статистик мэдээ цуглуулж, түгээх хүчин чадал нь тухайн улс орны эн тэргүүний бодлого, статистикийн туршлага, хүн ард болон санхүүгийн нөөц боломжоос хамаарч харилцан адилгүй байдаг. Үндэсний түвшинд тохируулан ашиглаж болохуйц уян хатан байдлаар уг хамрах хүрээг боловсруулсан.

Түүнчлэн энэ хамрах хүрээ нь соёлын салбарын загвар болох *соёлын мөчлөгийн* ухагдахуунд тулгуурласан тул харилцан адилгүй соёлын харилцааг ойлгоход дөхөм болно. *Соёлын мөчлөг* гэдэг нь үйлчлүүлэгч, оролцогч, хэрэглэгчдэд хүрч үйлчилдэг соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний үзэл санааг дамжуулагч бөгөөд дадал, үйл ажиллагаа болон шаардагдах нөөц боломжийн нэгдэл юм.

Тухайн хамрах хүрээ нь соёлыг хэмжихийн тулд хангалттай тоо баримтыг харьцуулах, мэдээллийн сан бүрдүүлж ашиглах чадварыг дээд хэмжээнд байлгах зорилгоор орчин үеийн ач холбогдол бүхий олон улсын ангилах систем, стандартыг өөртөө агуулдаг. Эдгээр ангиллын системүүд нь соёлын мэдээ мэдээлэл цуглуулж, түгээх иж бүрэн хүрээг ашиглах боломжийг улс орнуудад олгоно. Соёлын статистикийн хүрээг ашигласнаар зөвхөн соёлын үйл ажиллагаа бус бараа бүтээгдэхүүний хэрэглээ, үйлчилгээнд эдийн засгийн стандарт статистикийг хэрэглэж болохоос гадна өрхийн тухай судалгаа мөн ажил эрхлэлттэй холбоотой бүхий л статистикийн судалгаа хийх боломжтой. Үндэсний соёлын статистикийн хүрээгээ тодорхойлоогүй улс орнууд ч уг соёлын статистикийн хүрээний суурь бүтцийг ашиглаж болно. Харин статистикийн баялаг сантай улс орнуудын хувьд соёлын салбарын эн тэргүүний бодлогыг тусгаж, тусгайлан боловсруулсан, сайтар тохируулсан арга хэрэгслийг ашиглан статистикийн илүү нарийвчилсан тоо баримтыг цуглуулах боломжтой.

Уг хамрах хүрээнд тодорхой үзүүлэлтийг тодорхойлж, зааж өгөөгүй. Соёлын үзүүлэлтийн хамрах хүрээ болон холбогдох үзүүлэлтүүдийг боловсруулах нь үндэсний болон олон улсын түвшинд аль алинд нь тун чухал дараагийн алхам болно.

1. Удиртгал

Энэхүү ССХ нь ЮНЕСКО-гийн 1986 оны соёлын статистикийн хүрээг орлоно (ЮНЕСКО, 1986). ЮНЕСКО-гийн анхны статистикийн хүрээг боловсруулж гаргаснаас хойш соёлыг хэмжихэд олон чиглэл хандлага гарч байсан бөгөөд дэлхий ертөнцийн нийгэм, техник технологийн өөрчлөлт нь дэлхийн соёлын байр суурийг өөрчилсөн.

Соёлын статистикийн олон улсын хамрах хүрээ нь холбогдох боломж бололцоотой бол олон улсын хэмжээний харьцуулалт хийх боломжийг дээшлүүлэхийг зорьдог. Үндэсний хэмжээнд бол тухайн улсын статусыг бүс нутгийн болон дэлхийн бусад улс үндэстнүүдтэй харьцуулахад ямар байгаа талаар мэдэж авахын тулд баримтад тулгуурласан мэдээ мэдээлэлтэй байх шаардлага тулгардаг.

Энэ хамрах хүрээ нь соёлын нийгмийн болон эдийн засагт оруулж буй хувь нэмрийг үнэлэх үндсэн үзэл санаанд тулгуурласан. Энэ нь гишүүн улс орнуудын хувьд өөрсдийн соёлын статистикийг цуглуулах, дамжуулахад туслах чухал арга хэрэгсэл болох учиртай. Үүний тусламжтайгаар ЮНЕСКО, олон улсын агентлаг, мэдээ мэдээлэл ашиглагч нийгэмлэгүүдэд зориулж үндэсний болон үндэстэн хоорондын соёлын статистикийн мэдээ баримт боловсруулах боломжтой.

Энэ шинэ хамрах хүрээ нь ямар нэгэн хязгаар тавих бус харин уян хатан байж харьцуулалтыг хөгжүүлэхэд нөлөөлөх үүрэгтэй. Түүнчлэн улс орнууд өөрсдийн соёлын статистикийн хэлбэрийг бүрдүүлэгч үндсэн салбаруудаа шилж авах замаар өөрийн хамрах хүрээг бий болгоход нь тус дэм үзүүлэх зорилготой. Мөн энэхүү хамрах хүрээнд тохирох тодорхойлолтыг салбар тус бүрээр нь ашигласнаар улс орон бүр өөрсдийн тоо баримтыг олон улсын хэмжээнд харьцуулах боломжтой болно.

1.1 Үндэслэл

1986 оноос хойш нийгэм эдийн засгийн хамрах хүрээнд соёлын гүйцэтгэх үүрэг, ойлголт өөрчлөгдсөөр ирсэн. Соёл болон хөгжлийн хоорондын хамаарлын ач холбогдлыг тусламжийн агентлаг, мэргэжилтнүүд улам илүү мэдэрдэг болсон. Соёлыг хөгжил гэдэг үгтэй ижил утгаар авч үзэх нь улам бүр ихэсч, хөгжлийг гол хөдөлгөгч хүч, эдийн засгийн тогтвортой үйл явц, бидний оршин тогтнохын утга учир гэж үзэх болсон. Соёл нь аялал жуулчлал, гар урлал, түүхэн дурсгалын үр шимээр улс орны болон бүс нутгийн тогтвортой хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулан, ашиг орлогын эх үүсвэр бий болгох боломжтой. Соёл нь хүмүүсийн зан байдал, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулж буй тэдний хувь нэмэр, тэдгээрийн нийгмийн хөгжил, сайн сайхан байдалд нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрөх болсон (ЮНЕСКО, 1995).

Улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжилд соёлын зүгээс үзүүлэх нөлөөг дараах байдлаар дүгнэж болно:

- Соёлын үйлдвэрлэлд эдийн засгийн нөлөө үзүүлж, нийгэм болон соёлын шинэчлэлд нөлөөлөх замаар нутгийн ард иргэдийн соёлын өв хөрөнгө нь орон нутгийн тогтвортой хөгжилд дэмжлэг болохоор зохицсон.

- Соёл нь хүүхэд, эмэгтэйчүүдэд бүтээлч үйл ажиллагаанд оролцох боломж олгосноор хүйсийн тэгш байдлыг хангах, өөрийгөө хүндэтгэх, нийгмийн амьдралд оролцох боломж олгоно. Соёлыг бодолцсон бодлого нь уламжлалт ёс заншлаа хадгалж, нийгмийн эрх ашиг нь хөндөгдсөн бүлэг болох нутгийн уугуул иргэд, эмэгтэйчүүдийн эрх, ашиг хэрэгцээг хадгалахад тусална. Эмэгтэйчүүд бол дадал туршлагыг өвлөн, соёлын үнэт зүйлс, уламжлалыг хадгалан дамжуулагчид юм (ЮНЕСКО, 1995).
- Нилээдгүй соёлын үйлдвэрлэл нь орон нутагт суурилсан гол төлөв жижиг бизнес эсхүл гэр бүлийн аж ахуй эрхлэлтээс бүрэлддэг.

Соёлын ач холбогдлыг нэмэгдүүлэх зарим шалтгаан нь соёлыг удаан хугацаанд хадгалах хандлагад оршдог бол бусад шалтгаанууд нь саяхан болж өнгөрсөн үйл явдлаар тодорхойлогддог. Дэлхийн ихэнх бүс нутагт чинээлэг хангалуун байдал, чөлөөт орлого нэмэгдсэнээс болж соёлын үйл ажиллагаа, соёлын бүтээгдэхүүнд зориулсан зарлага байнга нэмэгдэхэд хүрсэн. Энэ нь илүүдэл мөнгөө сонирхол татсан эд бараа авч, тансаглахад зарцуулах бус эдийн засгийн нөхөн үйлдвэрлэлийн чухал бүрэлдэхүүн болох соёлын бүтээгдэхүүнд зориулдаг болсныг харуулж байна. Соёлын хэрэглээ өсч, бүтээгдэхүүний хамрах хүрээ нэмэгдэж, “бүтээгдэхүүн” нь одоо ихэнх соёлын дадлыг хүмүүст дамжуулж байна.

Энэхүү урт хугацааны чиг хандлага нь доорх сүүлийн үеийн, холбогдох хоёр үзэгдлээс болж эрчимжсэн:

- Соёлын үйлдвэрлэл өмнө нь үйлдвэрлэлийн аналог системийн улмаас хуваагддаг байсан бол (кино, телевиз, фото зураг, хэвлэл) одоо дижитал хэлбэрт шилжсэнээр өнөөдөр олонх тохиолдолд салгах боломжгүй болсон. Дижитал технологи нь соёлын бүтээлийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүний хэв загварт өөрчлөлт оруулсан. Тухайлбал интернэт ашигласнаар соёлын олон янзын бүтээлийг түгээхэд дангаар нь өргөн ашиглах бололцоотой болсон.
- Даяаршил нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын шинж чанартай болгож, санаа, ажилчид, хөрөнгөө дэлхийн хэмжээнд солилцдог болгосон. Соёлын олон төрөл зүйл, соёлын харилцан нөлөөлөл нь шинэ бүтээгдэхүүн, шинэ дадал болон олон төстэй зүйлүүдийг бий болгосон.

Дижитал технологийг өмнөх үетэй жишвэл орчин үеийн тоног төхөөрөмж нь “цорын ганц хувь” бүтээл болох дууг хүртэл маш богино хугацааны дотор арилжааны журмаар ашиглах боломжтой болгосон. Уг шилжилтээс шалтгаалж дижиталаар дахин боловсруулах боломжтой, борлуулах боломжтой, борлуулах боломжгүй буюу ерөнхийдөө борлуулахад бэрх бүтээгдэхүүнүүдийн соёлын үйл ажиллагаануудын эдийн засгийн хүчин чадлын тэнцвэрт байдалд өөрчлөлт оруулсан (Бэрроуклах ба Козул-Райт, 2006).

Зарим хөгжингүй орны соёлын салбар нь (наанадаж л хүн амын ажил эрхлэлтийн байдлаар) өмнө нь бүрэлдэн тогтсон үйлдвэрлэлийн салбаруудтай (уул уурхай, автомашины үйлдвэрлэл гэх зэрэг) харьцуулахад эдийн засгийн ач холбогдол нь нэмэгдэж, экспортын хувь оролцоо мэдэгдэхүйц өссөн байна. Энэ цаг үед хөгжиж буй орнуудын соёлын эдийн засгийн нөлөө хүн амын ажил эрхлэлтэд бага харагдаж байгаа ч экспортын орлогын хувьд өндөр байна. Улмаар хөгжиж буй орнуудын өсөлт хөгжилд үзүүлэх соёлын нөлөө эерэг дүр зурагтай байна (Бэрроуклах ба Козул-Райт, 2006).

Соёлын салбарын бодлогын одоогийн хамрах хүрээ нь дижитал технологийн өмнөх үеийн нөөц, хүч, давуу талд тулгуурласан. Соёлын бүтээгдэхүүний шинээр бий болж буй хэлбэрүүдийг уг хамрах хүрээнд багтаахад зарим хүндрэлтэй зүйлүүд гарч байгаагаас соёлын өвийг хадгалах, оюуны өмч, олон талт байдал зэрэг салбарт шинэ бүтээлүүдийн зорилтдоо хүрэхэд нөлөөлөх чадавхийг бууруулдаг байна. Жишээ нь: хөгжмийн бүтээлийн зарим зохиолууд худалдааны хувьд амжилттай байдаг бол дижитал технологийн сэргээлтэд ордоггүй соёлын бүтээлүүд соёлын салбарт эзэлдэг байр суурийг нь хамгаалан хадгалахын тулд төрийн зүгээс хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байдаг. Үүнтэй нэг адилаар эдгээр өөрчлөлт нь тухайн нөхцөл байдлыг дахин үнэлж дүгнэхэд хүргэдэг.

Түүнчлэн соёлын бүтээгдэхүүний шинээр бий болж буй хэлбэрүүд нь энэ салбарын янз бүрийн дэд бүлгүүдийн үйл ажиллагаатай холбоотой бодлогын шинэ салбарыг бий болгодог бөгөөд эдгээрийг заримдаа бүтээлч салбар гэж нэрлэдэг(2.2-р хэсгийг үз). Соёлын салбарын худалдааны хэмжигдэхүүн соёлын үйлдвэрлэлд өмнө нь чухал ач холбогдолтой байсан ч энэ хамрах хүрээ нь соёлын салбарын хувийн болон нийтийн харилцааны үйл ажиллагаанд хамааралтай хүчтэй, бүрэн бүтэн болон олон талт хандлагыг дэмждэг. Жишээ нь: дадлагажигчид ажлын хөлсөө улсад эсвэл хувьд, цалинтай эсвэл цалингүй, долоо хоногоор ажиллаж болох тул тэднийг улсын эсвэл хувийн салбарын алинд хамааруулахыг тодорхойлоход бэрх байдаг. Хэрэв дадлагад анхаарвал энэ хамрах хүрээ нь хязгаарлалтыг өөрчилж, бие биенийхээ элементүүдийг харилцан бэхжүүлэх чанарыг үнэлж болно.

Соёлыг бүтээж, боловсруулж, түгээх эдгээр шилжилт нь соёлыг эдийн засгийн уламжлалт салбаруудаас урьтаж харьцангуй бөгөөд үнэмлэхүй чанараараа давуу байгааг харуулж байна. Соёлын бүтээгдэхүүний хурдацтай өөрчлөлт, шинэлэг шинж чанартай холбоотойгоор эдгээр өөрчлөлтийн түвшин, даацтай чанарыг бүрэн дүүрэн үнэлэхэд олон тооны, илүү сайн мэдээ баримтууд шаардлагатай. Доор тэмдэглэсэнчлэн соёлын салбар жигд бус хөгжиж байна. Улмаар арилжааны болон арилжааны бус үйл ажиллагаа, уламжлалт болон орчин үе, олон улсын болон уугуул хүн амын хооронд олон нийтийн эмзэг асуудал, зөрчилдөөнийг үүсгэж байна.

1.2 Соёлын статистикийн хүрээг өөрчлөх болсон бодлогын нөхцлүүд

Соёлын статистикийн хүрээг 1986 онд гарснаас хойш төрийн бодлогод соёлын ач холбогдол хэрхэн өссөнийг дараах байдлаар тайлбарлаж болно:

- Дэлхийн хэмжээнд соёлын бүтээгдэхүүний олон улсын худалдаа өссөн. Улмаар оюуны өмчийн эрхийг (тэдний бүтээл, эзэмшигч, ашиглалт) чангатгахад голчлон нөлөөлж, тэдний соёлын ижилсэл болоод эзэмшлийн илүү өргөн хүрээтэй асуудлуудад ч (биет бус соёлын өв зэрэг) нөлөөлсөн.
- Соёлын салбарт үйл ажиллагаа явуулдаг үндэстэн дамнасан цөөн хэдэн компанийн зах зээлд эзлэх байр суурь өсч, төвлөрсөн. Соёлын үйлдвэрлэлийн зохион байгуулалт зах зээл дээр дангаар ноёрхоход таатай нөлөө үзүүлэх болж, үүнтэй холбоотойгоор “анхны эзэмшигчийн эрх” бараг бүхлээрээ хөгжингүй орнуудад төвлөрөх болсон. Үүнээс үл хамаарч интернэт нь мөн конгломератуудаас гадуур түгээх зах зээл, сувгуудыг хөгжүүлж зохиогчийн эрх зөрчигдөх үзэгдлийг нэмэгдүүлсэн.

- Соёлын үйлдвэрлэлд өсөлт гарахаас өмнө соёлын журам, сурталчилгааны хуулийн болон бодлогын институтууд бий болсон тул тэдгээр институтууд өнөөгийн асуудлуудыг шийдвэрлэх чадваргүй. Тохирсон бодлогын үндсийг боловсруулахын тулд тодорхой бат бөх бааз суурьтай байх ёстой. Соёлын салбарыг шинжлэхэд статистик эх сурвалжуудыг баримтжуулах соёлын чиглүүлэх баримт бичгүүд тун чухал юм.
- Соёлын бодлого нь “соёлын үйлдвэрлэлийн” бодлогын адил салбарын болон эдийн засгийн хандлагыг боловсруулахад чиглэнэ. Үүнээс улбаалж соёлын салбарын бодлогод соёлын үйлдвэрлэлийг тооцож үзвэл зохино.
- Энгийн хоёрдмол байдлын хамрах хүрээнээс давсан нийтийн болон хувийн салбарын хооронд нарийн харилцан хамаарал байдаг. Жишээ нь: олон тооны арилжааны соёлын үйл ажиллагаанууд салбарынхаа бодлогод нөлөөлөх хандлагатай. Дуализмаар хязгаарлагдсан хүрээ нь тун хангалтгүй болно.
- Бүс нутгийн түвшинд ядуурлыг бууруулахад чиглэсэн соёлын үйлдвэрлэлд хөрөнгө оруулах “хоёр санаачлага” үүнд хамаарна:
 - БХОТЭХАБ-2006 (BIMSTEC-2006) гишүүн орнуудын Паро санаачилгад мэдэгдсэнээр: “Соёлын үйлдвэрлэл нь ядууралтай тэмцэхэд хувь нэмрээ оруулж чадах бөгөөд нийгмийн өөрчлөн байгуулалт, орон нутгийн нэгдлүүдийн сэргэн мандалт ялангуяа, хөдөө орон нутгийн хүн амын нэн ядуу давхарга, хотын ядуучуудын дунд нөлөө бүхий хэрэгсэл болохоо харуулж чадсан” гэжээ.
 - Африкийн холбооны (Африкийн холбоо, 2005) соёлын сайд нарын бага хурлын нэгдүгээр чуулганаар боловсруулсан Африкийн соёл, уран бүтээлийн салбарын Найроби улсын төлөвлөгөө болон Альжирт болсон Африкийн холбооны сайд нарын хоёрдугаар чуулганаас гаргасан (Африкийн холбоо, 2008) төлөвлөгөөний дүгнэлт, зөвлөмжүүд төстэй агуулгатай. Төлөвлөгөөний гол зорилго нь Африкийн жүжигчид, уран бүтээлчдийн ажил, амьдралын нөхцлийг сайжруулж, Африкийн хөгжилд оруулж буй соёлын үйлдвэрлэлийг дэмжихэд оршино. Бусад зорилгуудад Африкийн соёлын болон бүтээлч салбаруудын хамгаалалт, зохион байгуулалт, үйлдвэрлэл, маркетинг, түгээн дэлгэрүүлэлт, үзэсгэлэн зохион байгуулах ажлыг хөнгөвчилж, хамгаалах, мөн Африкийн хэтийн төлөвийг соёлын болон бусад салбарын ирээдүйн хөгжлийн стратеги, технологийн салбараас аль болох их ашиг олох нөхцлийг бүрдүүлж байршуулах зэрэг зорилтууд багтана (Африкийн холбоо, 2008). Үйл ажиллагааны төлөвлөгөө соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийн статистикийн тоо баримт цуглуулах шаардлагыг мөн чиглэсэн.

1986 оноос хойш соёлын олон янзын хэлбэрүүдийн хөгжил илэрч, улмаар илүү идэвхтэй бодлого явуулах шаардлагатай болсон. Соёлын олон төрөл зүйлийг хамгаалан хөхүүлэн дэмжих тухай ЮНЕСКО-гийн 2005 оны конвенцид (ЮНЕСКО, 2005а) уг хөгжлийн талаар мөн тусгасан. Эдийн засагт оруулж буй бүтээлч хувь нэмрийг харгалзан үзэж соёлын олон төрөл зүйлийг бүтээлч байдал, шинэ санаачлагын үндсэн нөхцөл гэж үзжээ. Дэвид Тросби (2005) “...Соёлын олон төрөл зүйл нь үзэл баримтлал, сүсэг бишрэл, уламжлалын болон урлагийн олон талт болоод уран сайхан, соёлын бүтээлч үйл ажиллагаа бөгөөд соёлын өргөн хүрээтэй үйлчилгээ үзүүлдгээрээ бусад төрлүүдээс ялгардаг. Энэ нь соёлын олон төрөл зүйлийг дэмжих зарчмын урьдач нөхцөл болдог. Соёлуудын олон төрөл зүйл нь уран сайхны амьдралын хөгжилд мэдэгдэхүйц хувь нэмэр оруулдаг нь эргээд эдийн засагт нөлөөлдөг” гэжээ.

Соёлын олон төрөл зүйлийн хоорондын ялгаатай хэлбэрүүд нь газар орны байрлалын түвшинд анхаарал тавьдаг ба бодлогын олон талт хүрээтэй байдаг нь улс орны дотоод, гадаад болон үндэстэн дамнасан байрлал зэрэгт хамаарна. Соёлын төрөл зүйлүүдийн талаар идэвхтэй бодлого явуулахад хоорондоо холбоотой хэд хэдэн аспектиуд байдаг. Эдгээрт:

- Хөгжиж буй орнуудад бүтээгдэж буй соёлын бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ ерөнхийдөө нэмэгдсэн бөгөөд зарим тохиолдолд тэднийг хөгжингүй орнуудтай хамтран бүтээсэн байдаг. Соёлын экспортын орлогын асуудал үүсэхэд хөгжиж буй орнуудад хөгжингүй орнуудаас бага орлого ноогддог нь тэдэнд орон нутгийн эрх зүйн боломж байхгүйд оршино. Үүний учир нь хөгжингүй орнуудын монополь секторууд давамгайлах шинжтэй байдагтай холбоотой.
- Соёлын талаарх ойлголтуудын хооронд (ихэнхдээ Барууны) дээд болон доод болон түүний дотор барууны болон “үлдсэн нь” хэмээн соёлуудын хоорондын заагт сэв суусан;
- Хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжлийн стратегид гар урлалын бүтээгдэхүүний арилжааны ач холбогдол түүний гүйцэтгэх үүрэг.

Эдгээр өөрчлөлтүүдийн үр дагавраас болж олон асуудал үүссэн нь оюуны өмчлөлийн эрхийн асуудал ихээхэн маргаан үүсгэх болсон. Соёлыг өргөн хэрэглээний бараа гэж улам ихээр үзэх болсноор бүтээлч санааг нь ашиглаж байгаа хүмүүсийг хамгаалах асуудлын түвшинг эрхийн системээр тодорхойлох шаардлагыг бий болгосон (тодорхой үйлдвэрлэгчдийн тохирох эрхийг тодотгох). Энэ салбарт гарч буй хуулбарлах, хулгайлах асуудлаар, эн тэргүүнд томоохон корпорациуд өөрийн санааг хамгаалах талаар их ярих болсон. Үүний зэрэгцээ худалдаа арилжаатай холбоогүй соёлын салбаруудын эрх тодорхой бус байгаагаас болж хулгайн халдлагад өртөх магадлал өндөр байна. Энэ асуудлыг ил гаргаж тавьдаггүй, хөгжиж буй орнуудад байсаар байгаагаас болж соёлуудын ялгаатай байдалд заналхийлж байна. Энэ учир шалтгааны улмаас ЮНЕСКО-гийн 2005 оны конвенцид “соёлын ялгаатай, олон төрөл зүйлийн илрэлийг хөхүүлэн дэмжих, тэдгээрийг хамгаалах асуудлыг онцолж, соёлын үйл ажиллагааны эдийн засаг, соёл гэсэн хоёрдмол шинж чанарыг тодорхойлоод энэхүү хоёрдмол шинжтэй соёлын үйл ажиллагаа, чинээлэг хангалуун байдал, үйлчилгээ нь соёлын ижилсэл, үнэ цэнэ, ач холбогдлыг дамжуулан тээгч нь байдаг” гэжээ (ЮНЕСКО, 2005а). 2001 оны соёлын олон төрөл зүйлийн тухай тунхаглалдаа ЮНЕСКО “Соёлын олон төрөлт байдлыг байгаль өөрөө олон хувилбартай байдаг шиг хүн төрөлхтөнд зайлшгүй хэрэгтэй бөгөөд энэ нь солилцоо, шинэчлэл, уран бүтээлийн эх булаг. Гэхдээ “эдийн засгийн хөгжил шиг ойлгомжтой эх булаг бус, харин сэтгэл хөдлөл, ёс суртахуун, оюун санаа, мэдлэг оюуны хувьд оршин байх арга хэрэгсэл гэж ойлгох хэрэгтэй юм” гэж тодорхойлжээ. Энэхүү арга хэрэгслийн хоёр зарчим бол соёлын бүхий л илэрхийлэлд, тогтвортой хөгжилд хүрэх нэг адил боломж юм.

1986 онд гаргасан ССХ-г (ЮНЕСКО, 1986) ЮНЕСКО-гийн хөгжингүй орнууд зонхилсон гишүүн орнууд боловсруулсан юм. Энэхүү шинэчилж боловсруулсан ССХ-д хөгжиж буй орнуудын эрэлт хэрэгцээг анхаарсан. Тухайлбал биет бус соёлын өв, албан ёсны бус эдийн засаг, түүнчлэн соёлын олон төрөл зүйлс зэрэг нэгдсэн элементүүдийн зөв зохистой, хэрэгжих боломж бололцоотой байдлыг тусгасан байна. 1986 оны хамрах хүрээнд соёлын үйл ажиллагааны төрлүүд болох ардын гар урлал, боловсролын үүргийн тухай асуудал орхигдсон буюу зохих хэмжээнд тусгагдаагүй байсан юм.

1.3 Соёлын статистикийн хүрээг дахин хянаж шинэчлэх ажиллагааны зорилго, үндсэн зорилтууд

Уг хамрах хүрээ нь соёлын бүтээл, түгээлт, ашиглалтын үйл ажиллагааны бүхэл гинжин холбоог олон улсын хэмжээнд харьцуулах боломж олгодог харилцан ойлголцлыг хангадаг гол үзэл баримтлалын үндсийг бүрдүүлнэ. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд дараах үндсэн зарчмуудыг тус хамрах хүрээнд ашигласан болно. Үүнд:

- Соёлын бүтээлч үйл ажиллагааны бүх хүрээг нийгэм, эдийн засгийн хэрэгжүүлэх арга хэрэгслээс үл хамааран үзэл баримтлалын үндсийг бүрдүүлсэн.
- Соёлын бүтээлч үйл ажиллагааны бүх хүрээг (соёлын хэлбэрүүд, практик, бүтээгдэхүүн, үйл явц) хамруулахдаа тэдгээрийг бүтээж, хэрэглэх шинэ хэлбэр (соёлын үйлдвэрлэл болон оюуны өмчийн соёлын бүрэлдэхүүн) мөн соёлын үйлдвэрлэлтэй холбоогүй (биет бус соёлын өв) соёлын практик зэргийг багтаасан.
- Олон улсын ангиллууд руу хөрвүүлэх боломжтой Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал (БҮНА), Бүтээгдэхүүний тодорхойлолт, түүнийг кодчилох уялдаат систем (УС), Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, (ЭЗБТҮАСА), Ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал (АМОУСА) зэрэгт боломжит ангиллуудыг ашигладаг.
- Олон улсын харьцуулалт, жишиг гаргах суурь баазгүй орнуудад өөрийн онцлогийг тусгасан орон нутгийн хамрах хүрээг бий болгон хөгжүүлэхэд нь туслах зэрэг үйл ажиллагаанууд багтана.

2. Соёлын статистикийн хүрээ: Үзэл баримтлал ба бүтэц

2.1 Соёлын статистикийн хүрээний хянан шинэчлэлт: Шинэ хандлага

Соёлын статистикийн шинэ хамрах хүрээнд тулгараад байгаа асуудал нь соёлын бодлогын ялангуяа соёлыг хэрхэн яаж хэмжих тухай маргааныг үүсгээд байгаа хуваагдмал эсрэг тэсрэг байдлыг арилгах арга замыг боловсруулах явдал юм. Энд хэрэглэж байгаа арга зам нь соёлын бодлого дахь дараах гурван шинжээр илрээд байгаа хоёрдмол байдлыг арилгахад чиглэгдэнэ:

i) **Соёлын статистикийн хүрээ (нийгэм, эдийн засгийн).** Энэхүү хандлага, арга зам нь соёлын санаа сэдэл хэрхэн үүсч, дамжиж ирсэн тухай ойлголтод тулгуурладаг. Соёлыг бүтээх, түгээхэд чиглэсэн энэхүү чиг хандлага нь уг соёлын санаа нийгэм, эдийн засгийн үйл явцтай нягт холбоотой болохыг ойлгуулна. Соёл нь нийгэм, эдийн засгаас салж, тусдаа оршин тогтнодоггүй. Зах зээлтэй холбоогүй элементүүдийн үзүүлэлтүүдийг оруулаад соёлын олон элементүүд оролцоо, зарцуулсан цаг буюу нийгмийн капитал зэрэг үзүүлэлтүүдээр дамжиж илэрдэг. Соёлын үйлдвэрлэл, дамжуулахтай холбоотой бусад олон үйл явцууд хэмжиж болохуйц эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой байдаг.

ii) **Засаглалын хэлбэр (улсын, хувийн).** Энэхүү арга зам нь соёлын үйлдвэрлэл, дамжуулалтын явцад санхүүжилт болон засаглалын төрлөөс (хувийн сектор, улсын байгууллага эсвэл иргэний байгууллага) хамаардаггүй. Соёлын санхүүжилтийн гурван эх үүсвэр нь а) улсын (ихэнхдээ засгийн газар, улсын байгууллагаас) - энэ нь шууд (тэтгэмж буюу буцалтгүй зээл), шууд бус хэлбэрээр (татвараас чөлөөлөх г.м) олгогддог, б) хувийн (зах зээлээс), в) ашгийн төлөө бус байгууллагууд буюу хандивлагчид зэргээс бүрдэнэ. Соёлын санхүүжилтийн эдгээр гурван эх үүсвэрийн талаар одоогийн байгаа мэдээлэл дээр үндэслэн нарийн дүр зургийг гаргах боломжгүй. Европын орнуудын соёлд зориулсан санхүүжилтийн талаарх харьцуулсан, цэгцтэй мэдээллийг олж авах ихээхэн ярвигтай байгааг ажлын хэсгийнхэн олж мэдсэн (Европын Хороо, 2001). Олон улс орнуудад хэрэглэдэг улсын санхүүжилтийн (төвлөрсөн эсвэл төвлөрөөгүй) олон янзын бүтэц нь харьцуулалт хийхэд улам ярвигтай болгож байна.

Уг хамрах хүрээ нь соёлын салбар дахь харилцаа холбоо болон солилцооны бүтцийн зааг ялгаан дахь салбарт онцгой анхаардаг.

iii) **Институтчлэх зэрэглэл (албан ба албан бус).** Энэхүү чиг хандлагаар бол соёлын салбарын үйлдвэрлэл, түгээлтийг албан болон албан бус эдийн засаг, нийгмийн хүрээнд явагддаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Соёлын албан бус үйлдвэрлэл нь хөгжингүй ба хөгжиж буй орнуудад түгээмэл байдаг. Гэхдээ соёлын үйлдвэрлэл албан бус эсвэл мөнгөн бус харилцаан дээр үндэслэсэн бол түүнд үнэлгээ өгөх боломжтой. Энэ хандлага, арга зам нь соёлын бүтээлч үйл ажиллагаа, илэрхийлэл, ач холбогдлын бүх талыг аль болох бүрэн дүүрэн зохицуулахад чиглэнэ (2.3-р хэсгийг үз).

Соёлын үйлдвэрлэлд хөдөлмөр эрхлэлт улам бүр мэргэжлийн шинж чанартай болж байгаа нь соёлыг “бүтээх” болон түүнийг “ашиглах” хоёрын хоорондох үүрэг зорилтын ялгааг улам нарийн гаргахыг шаардаж байгаа ч гар урлал болон үүнтэй адил төстэй салбаруудад үйлдвэрлэгчид бүтээлээ өөрсдөө санаж сэдэн, өөрсдөө бүтээн бий болгож, үзүүлэн таниулж, худалдаалан борлуулдаг тул хөдөлмөрийн үүрэг оролцооны ялгаа арилдаг. Иймээс ардын гар урчууд соёлын үйлдвэрлэлийн хэд хэдэн мөчлөгт биечлэн оролцож болно.

Тухайн хамрах хүрээг хянан шинэчлэх учир шалтгаан нь дараах гурван хэсгийг хамарч байна. Үүнд:

- **Салбарыг бүхэлд нь хамрах** (соёлын гэх бүх салбарууд багтана) түүний **гүнд орох** (гүйцэтгэгчид, жүжигчид, тэдэнд зайлшгүй шаардлагатай байдаг туслах ажилчид болон эд хэрэгслүүд)
- **Шууд үзүүлэлтэд чиглэсэн** хөдөлгөөн хандлага
- **Олон улсын хэмжээнд харьцуулан үнэлгээ өгөх** чадвар. Үүний зэрэгцээ “бүгдийг нэг хэмжүүрээр хэмжихэд” хүргэхгүй байх чадварыг бүрдүүлэх нь тун чухал юм. Энэхүү хамрах хүрээнд бүс нутаг буюу орон нутгийн өвөрмөц болон олон төрөл байдлыг хадгалахын зэрэгцээ тэдгээрийг харьцуулах боломжийг хангах шаардлагатай.

2.2 Соёлыг статистикийн зорилгоор тодорхойлох нь

Соёлын тухай ойлголт нь соёлын олон төрөл зүйлийн талаарх ЮНЕСКО-гийн дэлхий нийтийн тунхаглалын тодорхойлолт дээр үндэслэдэг бөгөөд энэ нь *“соёлыг нийгмийн эсвэл, нийгмийн бүлгийн өвөрмөц онцлог бүхий оюун санаа, материаллаг болон оюун санааны, түүнчлэн урлаг, утга зохиол, амьдралын хэв маяг, хамтын амьжиргааны арга хэрэгсэл, үнэт зүйлийн систем, уламжлал болон итгэл үнэмшлийг хамарсан цогц бүрдэл гэж ойлгон хандах ёстой”* гэжээ (ЮНЕСКО 2001). Соёлын тухай энэхүү тодорхойлолт нь нийгэм, бүлэг, олон нийтийн өөрсдийн өвөрмөц онцлогийг илэрхийлэх арга хэрэгсэлтэй нягт холбоотой.

Статистикийн зорилгоор соёлыг тодорхойлоход хоёр үндсэн хүчин зүйлийг харгалзаж үзсэн. Үүнд:

- **“Соёлын салбарын” үзэл баримтлал:** Соёлын тухай тодорхойлолтыг одоо мөрдөж буй ангиллыг ашиглан албан ёсоор тодорхойлж болох учир хэд хэдэн үйлдвэрлэлээс эхэлж болно (тэдгээрийг нийтэд нь соёлын үйлдвэрлэл гэж нэрлэнэ). Салбар нь нийгмийн болон албан бус хэлбэрийг багтаан зохих ёсоор нэрлэсэн соёлын бүх үйл ажиллагааг хамарна. Жишээ нь: арилжааны кино болон уран сайхны кино үзэгчдийн тоог багтаасан кино үйлдвэрлэлийн статистик үзүүлэлт. Үүнд: гэртээ хийсэн кино бичлэг болон түүнийг үзүүлэх зэрэг үйл ажиллагаанууд багтана. Иймэрхүү олон нийтийн буюу албан бус үйл ажиллагаа нь соёлын үндсэн хэсгийг бүрдүүлдэг бөгөөд одоогийн статистикийн хэрэгслийг ашиглан тодорхойлоход хүндрэлтэй байгаа тул ССХ-д арга зүйн өөр хэлбэр шаардаж байна. Энэхүү хамрах хүрээний хэтийн төлөвөөс харахад тус соёлын салбар нь үйл ажиллагаатай холбоотой эдийн засаг, нийгмийн бүх хүрээг хамарч байна.

- **Бүтээлч - соёлын мэтгэлцээнүүд:** Олон оронд эдгээр салбаруудыг тайлбарлахдаа “бүтээлч” гэсэн нэр томъёог ашигладаг ч уг бүтээлч “салбар”-г хамаарах олон үйлдвэрлэлүүд мөн чанартаа бүтээлч биш байдаг. Бүтээлч байдлын тодорхойлолт, хэмжүүр нь өөрөө ямагт ширүүн маргааны бай болж байдаг. Бүтээлч үйлдвэрлэлүүд нь уламжлалт салбаруудтай харьцуулбал мэдээлэл харилцааны технологи, шинжилгээ судалгаа, боловсруулалт гээд илүү өргөн хүрээг хамрах болсон. Уг асуудлыг энэхүү хамрах хүрээгээр шийдвэрлэхдээ зарим тодорхой үйлдвэрлэлүүдийг (загвар, зар сурталчилгаа) тусдаа салбар болгон оруулж судална.

2.3. Соёлын мөчлөг

Соёлын мөчлөг нь бүтээн соёлыг бүтээх, үйлдвэрлэх, түгээх гээд бүхий л үе шатыг хамардаг. Эндээс харахад соёл гэдэг нь хоорондоо адил төстэй үйл явцуудын бүтээгдэхүүн юм. Энэ үйл явцууд нь шат дараалсан зохион байгуулалттай эсвэл зохион байгуулалтгүй, эсвэл төрөөс удирдан зохицуулагддаг эсвэл зохицуулагддаггүй гэсэн хэлбэртэй байж болно. Энэ салбарыг өргөн утгаар авч үзвэл, “салбар” гэсэн тодорхойлолтод зах зээлтэй холбоогүй албан бус, сайн дурын үйл ажиллагаа хамаарах бол үзэл баримтлалд зах зээлтэй холбоогүй ч эдийн засгийн, зах зээлтэй холбоотой үйл ажиллагаануудыг хамааруулсан.

Салбарт үндэслэсэн үзэл баримтлалын хөгжил нь үйлдвэрлэлийн мөчлөгийн дагуу тодорхойлсон соёлын үйлдвэрлэл, түгээлтийг ашиглах боломж олгодог. ЮНЕСКО-гийн зөвлөгөө судалгааны төвөөс (ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэн, 2006а) гаргасан улс орон болоод бүс нутгийн ангиллын дүгнэлтээс үзвэл хэд хэдэн гишүүн орнуудад соёлын мөчлөгийн үзэл баримтлал хэрэгжиж байна. Гэхдээ зарим тохиолдолд концепци нь бүхлээрээ бус эсвэл тууштай биш ашиглагдаж байна. Соёлын мөчлөгийн аргачлал нь амьдрал дээр соёлын бүтээгдэхүүн хэрхэн бүтээгдэж, соёлын үйл ажиллагаа яаж явагдаж байгааг ойлгох боломж олгосноор салбаруудыг энгийн аргаар бүлэглэснээс хавьгүй өргөн хүрээтэй байгааг ухамсарлан ойлгоход тустай.


Соёлын статистикийн тогтвортой бат бэх хамрах хүрээ нь соёлын ололтыг бий болгох, түгээх, хүлээн авах, хэрэглэх, шүүмжлэх, ойлгох болон хадгалах боломжтой үйл явц юм. Соёлын үйлдвэрлэл ба түгээлтэд шаардлагатай үйл ажиллагааны бүх талыг бүрэн илрүүлэн гаргах хэд хэдэн арга замыг боловсруулжээ. Янз бүрийн соёлын хэлбэрүүд харилцан адилгүй мөчлөгтэй байдаг тул үйл ажиллагааны үе шат бүрт жигд оролцдоггүй боловч эдгээрийг үндэслэн үйлдвэрлэлийн мөчлөгийн 5 үе шат болгон хуваах оролдлого хийжээ (Зураг 1).

Шаталсан загвартай бус, мөчлөгийн байдлаар гаргасан болохоор эдгээрийн харилцаа харьцангуй түвэгтэй, сүлжээ хэлбэрээр байж болох соёлын статистикийн 1986 оны ангилалтай нэг адил 5 үе шаттай.

1. **Бүтээн туурвих:** үзэл санаа болон агуулгыг бий болгон сэдэвлэх болон зохион туурвих (жишээ нь: уран барималч, зохиолч, загварын компаниуд), нэг удаагийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн хийх (жишээ нь: гар урлал, уран зураг) зэрэг болно.
2. **Бүтээгдэхүүн:** соёлын нөхөн бүтээгдэх хэлбэрүүд (жишээ нь: телевизийн хөтөлбөр) болон түүнийг бүтээхэд хэрэглэгддэг тусгай зориулалтын тоног төхөөрөмж, дэд бүтэц, үйл явц (жишээ нь: хөгжмийн зэмсэг үйлдвэрлэх, сонин хэвлэх г.м).
3. **Түгээлт:** ерөнхийдөө бөөнөөр үйлдвэрлэсэн соёлын бүтээгдэхүүнийг хэрэглэгч, үзэсгэлэн зохион байгуулагчдад хүргэх (жишээ нь: хөгжмийн бичлэг, компьютерийн тоглоомын бөөний болон жижиглэнгийн худалдаа, түрээс, кино түгээлт г.м). Дижитал түгээлтээр зарим бараа, үйлчилгээг зохиогчоос шууд хэрэглэгчдэд хүргэдэг.

4. **Үзүүлэх, хүлээн авах, дамжуулах:** цагийн хуваарь бүхий соёлын үйл ажиллагаа (жишээ нь: фестиваль зохион байгуулах, бүтээх, дуурийн театр, театр, музей)-нд оролцохын тулд бэлнээр болон борлуулалтын замаар үзэгчдэд шууд хүргэх газруудтай хамаатай. Дамжуулалт нь мэдлэг болон ур чадварын мэдлэгийг дамжуулах аливаа арилжааны болон албан бус зүйлд хамаардаггүй. Үүнд биет бус соёлын өвийг үеэс үед дамжуулан түгээх үүрэг багтана.
5. **Хэрэглээ/оролцоо:** үзэгч, оролцогчид соёлын бүтээгдэхүүнийг хэрэглэж, соёлын үйл ажиллагаанд оролцон, дадлага туршлага олж авдаг (жишээ нь: ном унших, бүжиглэх, багт наадамд оролцох, радио сонсох, уран зургийн галерей үзэх г.м).

Зураг 1. Соёлын мөчлөг



Соёлын мөчлөг гэх нэр томъёо нь эрэлтэд тохирсон соёлын шинэ бүтээгдэхүүн хийх урам зориг өгөх, эргэх холбоо бий болгож, эдгээр үйл ажиллагааны харилцан холбоог бүрдүүлнэ гэсэн үг юм. Загвар нь соёлын үйлдвэрлэлийг хийсвэрлэн ойлгоход тус болдог тул үүнийг загварыг хүлээн авах мэдрэмжийг нэмэгдүүлэх гэсэн хэсэгт хамааруулах нь зүйтэй. Амьдрал дээр эдгээрийн зарим үе шатууд нэгдэн нийлдэг. Жишээ нь: хөгжимчин хөгжим зохиож (бүтээх), тоглож (үйлдвэрлэж, түгээх) бол жүжгийн зохиолч зохиол бичдэг ч (бүтээх), харин тайзнаа тоглох (үйлдвэрлэж, түгээх) нь ховор байдаг. Түүхий эдээ өөрөө олж авч (албан бус нөөц), соёлын бүтээлээ уламжлалт арга барилд (албан бус сургалт) түшиглэн хувиараа гар урлал эрхлэгч нь зам дагуу бүтээлээ олны хөлийн газар (албан бус түгээлт, жижиглэнгийн худалдаа) борлуулдаг нь албан бус мөчлөгөөр ажиллагсад хамаарч байгаа хэрэг. Үйл явцын чухам аль хэсэг үнэлэгдэж байгааг хэрхэн ойлгосон нь соёлын үйлдвэрлэлд оролцох төрийн бодлогыг цаашид боловсруулахад чухал элемент болно.

Зарим соёлын үйл ажиллагааны хувьд соёлын мөчлөгийн ямар ч үед эхэлж болдог бол зарим үе шатанд хослуулж эсвэл заримд нь бүр байхгүй болдог өнгөрсөн үед хамаардаг соёлын өвийн жишээн дээр харж болох юм. Биет бус соёлын өвтэй холбоотой арга ажиллагаан дээр ихэнх үйл явц нь “үзүүлэх/дамжуулах”, “хэрэглэх/оролцох” гэсэн дамжлагатай байдаг.

Мөчлөгийн сүлжээний бүтэц нь голцуу шинэ технологитой холбоотой үйлдвэрлэлийн шинэ хэлбэрүүдийг бүрдүүлдэг. Эдгээр шинэ технологиуд харилцан адилгүй үүргүүдийн хооронд харилцан хамаарал үүсгэж, улмаар яваандаа соёлын үйл явцын эдгээр шинэ хэлбэрүүд тэдгээр үүргүүдтэй нийлж болно. Жишээ нь: You Tube болон блог гэх зэрэг арга технологи ашиглах явцдаа хүмүүс нэгэн зэрэг бүтээж, ашиглах боломжтой.

Соёлын мөчлөг нь нийгмийн харилцааны салбарт соёлын бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлоход тустай. Соёлын мөчлөгийн арга зүй нь ашиг орлоготой ч бай, өв уламжилсан соёлын үнэт зүйлсийг дамжуулагч ч бай, соёлын үйлдвэрлэлийн сэдэлжүүлэлтэд анхаарал хандуулдаггүй. Соёлын үйл ажиллагаа болон жүжигчид зах зээлийн болон зах зээлийн бус үйл явцын байнгын хөдөлгөөнд оршдог тул тухай бүрийн үүргийг хэмжин үнэлэхэд гарах бэрхшээлийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Соёлын мөчлөг нь үе шат бүрийн хэр зэрэг “соёлын” байх талаар үнэлгээ дүгнэлт хийдэггүй. Энд эн түрүүн санаа сэдлийг соёлын үйлчилгээ, бүтээгдэхүүн болгон хувиргаж, хэрэглэгч, оролцогч буюу ашиглагчдад хүргэдэг үйл ажиллагаа, нөөцийн хэр хэмжээг ойлгох, соёлын үйл ажиллагааг бүхэлд нь ажиглахад гол утга учир нь оршдог. Урлагийн бүтээл нь (уран зураг, ардын урлал эсвэл жүжгийн аль нь ч бай) тэдгээрийг үнэ цэнэ, ач Жишээ нь: ямар нэг улс орон тодорхой газар нутгийг үндэсний буюу онцгой соёлын өвтэй газар гэж үзвэл тухайн улс орны бодлого нь аялал жуулчлал, тээвэр, хамгаалалт, зочид буудал зэргийг хөгжүүлэхэд анхаарч зочдоос үзвэрийн ашиг олох боломжийг хангах ёстой.

Соёлын мөчлөг орон зайн хэмжигдэхүүнийг мөн агуулдаг. Үйл ажиллагааны зарим нь нэг газар, нэг бүс нутаг, нэг оронд байдаг бол нөгөө хэсэг нь бүх дэлхий даяар тархсан байх жишээтэй. Ийнхүү ангилахыг зөвхөн туршилтын замаар тодорхойлж болох бөгөөд энэ нь соёлын салбарын зохицуулалт болон түүнээс хэрхэн ашиг (нийгэм, эдийн засгийн) олох асуудлын цаашдын үр дагавартай ч холбоотой. Үүнтэй нэг адил орон зайн бас нэгэн чухал бүрэлдэхүүн нь хүмүүс уугуул соёлоосоо хөндийрөн өөр газар луу шилжин нүүдэллэж байгаа явдал юм. Даяарчлал нь шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлж, соёлын уусалтыг хурцдуулснаар гадны болон этгээд мэдрэмжийг бий болгож зөрчилдөөнт байдлыг нэмэгдүүлдэг.

Мөчлөгийн (соёлын статистикийн баазаас олж авсан) дүн шинжилгээнд ашигладаг эмпирик мэдээ мэдээлэл (чанарын ба тоон туршилтын) нь бүх орны хүрээнд хүртээмжтэй байдаггүй. Мэдээлэл цуглуулахад хөрөнгө мөнгө гаргадаг орнуудын хувьд соёлын түвшингийн хувь нэмэр харьцангуй их байдгийг энэ загвар харуулж байна. Гэхдээ тухайн мэдээлэл загварыг боловсруулж байгаа улс төрийн бодлого бүс нутаг, улс орнуудад хэр хүртээмжтэй байгаагаар жинхэнэ ач холбогдлыг нь тодорхойлдог.

Соёлын салбарын аливаа тодорхой бодлогод заавал бүхэл бүтэн мөчлөг байхыг шаарддаггүй. Гэвч бүхий л үе шатуудын хүрээнд бага хэмжээний, хязгаарлагдмал оролцоо ч мөчлөгийн хувьд ихээхэн хэмжээний үр дагаварт хүргэж болно гэдгийг бодлого тодорхойлогчид анхааралдаа авах ёстой.

2.4. Соёлын салбарын хамрах хүрээ

Дэлхий нийтийн соёлын статистикийн хүрээг нэгтгэн дүгнэж үзвэл (ЮНЕСКО, UIS, 2006a) соёл нь тодорхой бүрэлдэхүүнтэй бүлэг үйл ажиллагааны үр дүн болохыг харуулдаг. Гэсэн ч уг дүгнэлтээр дараах зүйлс ойлгомжгүй байгааг харуулж байна. Үүнд:

- i) Эдгээр үйл ажиллагаануудыг салбар хэлбэрээр илүү өндөр түвшинд хэрхэн хамтад нь бүлэглэх тал дээр хангалттай зөвшилцөлд хүрч чадахгүй байх;
- ii) Соёлын салбарын анализ судалгаанд ямар үүргүүдийг багтаан оруулах тал дээр нэгдсэн ойлголт бараг байхгүй зэрэг юм.

Зарим талаар эхний асуудлаар санал зөрүүтэй байгаа нь (i) орон нутгийн соёлын ялгааны бодит нөлөө юм. Гэхдээ энэ нь (ii) боловсруулсан үндсэн загвар эсвэл анализ судалгааны логик дутагдаж байгаатай мөн холбоотой. Энэ нь хожмын асуудлын үр үндэс болж байна.

Гэлээ ч нийцтэй, логиктой арга зам ашиглах нь соёлын статистикийн хүрээг хянан шинэчлэхэд тавигдах цорын ганц шаардлага биш юм. Дараах зүйлстэй холбоотой прагматик асуудлуудыг мөн анхаарах нь зүйтэй:

- **Хэрэгжилт** – бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал (БҮНА), эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ЭЗБҮҮАСА), ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал (АМОУСА), бусад олон улсын ангиллын алийг нь ч статистикийн ангиллын системийн соёлын салбарын тодорхойлолтыг хэрэгжүүлэх чадвар;
- **Бодлого** – томоохон ашиг сонирхол бүхий соёлын институциудтэй, энэ хүрээнд “өөрсдийгөө” багтаах сонирхолтой улс орнуудын дэмжлэг, баталгаа шаардлагатай соёлын хамрах хүрээг ашиглана (ийм учраас хэрэгцээтэй) гэдгийг баталгаажуулахуйц.

2.5 “Соёлын салбарууд”-ыг тодорхойлох нь

Соёлын салбарыг хэмжиж, түүнд хамаарах болон хамаарахгүй ангиллуудыг тодорхойлохын тулд соёлыг өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай. Прагматик буюу хэрэглээний арга замыг дагадаг хүрээний зорилтын хувьд бол доор дурьдсан соёлын үйл ажиллагааны тодорхойлолт нь уг баримт бичигт өмнө нь томъёологдсон ерөнхий тодорхойлолтонд үндэслэсэн юм (2.2-р хэсэг).

ССХ-д хэрэглэсэн соёлын прагматик тодорхойлолт нь үйлдвэрлэлийн ба үйлдвэрлэлийн бус үйл явцаас гарч ирдэг соёлын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг хэмжин үнэлэх зорилготой соёлын үйл ажиллагааны салбаруудын тухай ойлголт дээр үндэслэдэг. Соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээ нь уран сайхан, гоо зүй, бэлгэ тэмдэг, оюун санааны үнэт зүйлстэй холбоотой. Соёлын бараа, үйлчилгээний шинж чанар бусад бүтээгдэхүүнүүдээс ялгаатай байдаг учир нь юу вэ гэвэл тэдгээр нь нөхөн үйлдвэрлэх боломжгүй чанарыг агуулдаг бөгөөд тэдгээрийн талархал, сайшаалтай холбоотой (Тросби, 2001).

Соёлын бүтээгдэхүүнүүд нь үзэл санаа, бэлгэ тэмдэг болон амьдралын ёс заншил, хэв маягийг дамжуулдаг бөгөөд заримынх нь зохиогчийн эрх хамгаалагдсан байдаг. Соёлын үйлчилгээ нь соёлын биет бүтээгдэхүүнийг бус харин тэдгээрийн үйлдвэрлэл, түгээх үйл ажиллагааг хангана. Жишээ нь: тусгай зөвшөөрөл авах, зохиогчийн эрхтэй холбоотой бусад үйлчилгээ, аудио-визуал бичлэг түгээлт, урлаг-соёлын арга хэмжээний тоглолтыг дэмжих, мөн соёлын мэдээллийн үйлчилгээ болон ном, бичлэг, эртний дурсгалт зүйлсийг хадгалах (номын сан, баримт бичгийн төв, музей зэрэгт) зэрэг нь соёлын үйлчилгээнд багтана. Эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээг ихэнхдээ зохиогчийн эрхийн дагуу үзүүлнэ.

Соёлын үйл ажиллагаа нь тэдгээрт байж болох арилжааны үнэ цэнээс үл хамааран бүтээлийг дамжуулах буюу өөртөө агуулж байдаг. Соёлын үйл ажиллагаа нь бие даасан ач холбогдолтой эсвэл соёлын бараа, үйлчилгээний үйлдвэрлэлд хувь нэмрээ оруулж байж болно (ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэн, 2005).

1986 оны хамрах хүрээнээс ялгаатай нь (ЮНЕСКО, 1986), соёлын салбаруудын тодорхойлолт нь соёлын салбарууд болон холбогдох үйл ажиллагааны хүрээг бүрдүүлсэн шаталсан загварт тулгуурласан. Соёлын салбаруудад соёлын мөчлөгийн загварын янз бүрийн үе шатанд хамааралтай соёлын үйл ажиллагаа, бараа, үйлчилгээг багтдаг. Холбогдох салбарууд нь нийгмийн амьдрал, үзвэр үйлчилгээтэй холбоотой өргөн хүрээний үйл ажиллагаануудыг хамарна. Эдгээр салбарууд харилцан бие биедээ хамаардаггүй. Жишээ нь: хөгжим гэхэд л дан ганц ангилалд хамаарна. Хуучин 1986 оны ССХ-д биет бус соёлын өв нь “нийгмийн үйлчилгээ” гэсэн ангилалд хэсэгчлэн орж байсан бол биет бус соёлын өв нь одоо нийтлэг хамааралтай салбарт хамрагдах болсон.

2-р зурагт дүрслэн тодорхойлсон ССХ-ний соёлын салбарууд нь соёлтой холбоотой үйлдвэрлэл, үйл ажиллагаа, практикийн нэгдэл бөгөөд дараах байдлаар бүлэглэн хувааж болох юм. Үүнд:


- А. Соёлын болон байгалийн өв
- Б. Тоглолт ба баяр ёслол
- В. Визуал урлаг ба гар урлал
- Г. Ном, хэвлэл
- Д. Аудио-визуал болон интерактив медиа
- Е. Загвар ба бүтээлч үйлчилгээ
- Биет бус соёлын өв (нийтлэг хамааралтай салбар).

Эдгээр салбаруудыг соёлын салбарууд гэж үздэг. Эдгээр нь мөн ЮНЕСКО-гийн зүгээс улс орнуудыг харьцуулах мэдээ мэдээлэл цуглуулахыг дэмжиж буй соёлын салбаруудын наад захын багцыг төлөөлж байгаа. Энэ нь соёлын салбаруудыг хамрах үзүүлэлтүүдийг бүрэн хамарч бүтцийн тухай бүрэн дүүрэн ойлголт өгч байгаа юм.

Түүнчлэн соёлын үйлдвэрлэлийн дамжуулалтын үе шатанд голлох үүрэгтэй гурван өөр “нийтлэг хамааралтай” салбар байдаг. Тэдгээрийг нийтлэг хамааралтай салбарууд гэх учир нь соёлын болон тэдгээртэй холбоотой бүх салбарт бүгдэд нь хэрэглэгддэг. Үүнд:

- Боловсрол, сургалт
- Архив ба хадгалалт
- Тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслүүд багтана.

Зураг 2. Соёлын статистикийн салбаруудын хамрах хүрээ



Давхардуулахгүйн тулд үйл ажиллагаануудыг нэгээс илүү олон салбарт хамааралтай ч үйл ажиллагаа тус бүрийг систем дотор зөвхөн нэг удаа ангилах болно. Жишээ нь: хөгжмийг “Тоглолт, баяр ёслол”, “аудио-визуал бичлэг” гэсэн ангилалд хоёуланд нь хамааруулж амьд тоглолт (тоглолт) харин бичлэг нь (аудио-визуал бичлэг) гэсэн хоёр ангилалд оруулсан байна. Гэхдээ ССХ агуулгаар илэрхийлэгдэх хэлбэрт бус уг зүйлд нь илүү ач холбогдол өгч байгаа юм. Түүнээс гадна соёлын салбарын ихэнх хэсгийг статистик ангиллын хамрах хүрээнд урлагийн тоглолтын бусад төрлүүдээс тусгаарлаж болохгүй.

Соёлын салбарууд

ССХ-д соёлын салбаруудыг дараах байдлаар тодорхойлсон байна:

А. Соёлын болон байгалийн өв

Соёлын болон байгалийн өвийн салбарт музей, археологийн болоод түүхэн дурсгалт газар нутаг (үүнд археологийн малталт хийсэн газар, барилгууд багтана) *соёлын өвөрмөц тогтоц бүхий газрууд болон байгалийн өв* орно.

Соёлын өвд бэлгэ тэмдэг, түүх, уран сайхан, гоо зүй, удамшил, антропологи, шинжлэх ухаан, нийгмийн чухал ач холбогдол бүхий янз бүрийн үнэ цэнэтэй түүхэн дурсгалт зүйлс, хөшөө дурсгал, бүлэг барилга байгууламж, газар орнууд багтдаг.

Соёлын ландшафт гэдэг нь байгалийн үзэгдэл, хүний үйл ажиллагаа хоёрын урт удаан хугацааны нягт холбоо, түүнийг хүрээлэн буй байгаль орчин зэргийг тусгасан харилцан ууслын үр дүн юм (ЮНЕСКО, 2007).

Байгалийн өв нь үндэсний шинж байдал, геологи, физик газар зүйн тогтоц, хүрээлэн буй орчныг хамрах бөгөөд шинжлэх ухаан, хамгаалал, байгалийн гоо зүйн талаас авч үзэхэд үнэ цэнэтэй, устах аюулд өртөөд байгаа ан амьтан, ургамал байрладаг газар нутаг, байгаль орчноос бүрддэг. Мөн байгалийн парк, дархан цаазат газрууд, амьтны хүрээлэн, ус, ургамлын ай сав газрууд байгалийн өвд хамаарна (ЮНЕСКО, 1972).

Соёл, байгалийн өвтэй холбоотой үйл ажиллагаа гэдэг нь түүх, гоо зүй, шинжлэх ухаан, байгаль орчин, нийгмийн ач холбогдол бүхий газар нутаг, цуглуулгын удирдлагын асуудал юм. Энэ ангилалд музей, номын сангийн хадгалалт, архивын үйл ажиллагаа мөн багтана.

Музей гэдэг нь “нийгэм түүний хөгжилд байнга үйлчилдэг, нийтэд нээлттэй, боловсрол, судалгаа, сайн сайхны хүртэхийн тулд хүн төрөлхтний биет ба биет бус соёлын өв, тэдгээрийн байрлах газар нутгийг бүртгэн цуглуулж, хадгалан судалж, дүрслэн буюу биетээр үзүүлдэг ашгийн бус байгууллага” юм (ICOM, 2007). Энэ салбарт ангилсан музейн бусад төрлүүдэд нийтлэг бүлгүүд өнөөг хүртэлх зан үйл, шашны ёслолд хэрэглэдэг эд зүйлс хадгалагдан байгаа амьд түүхийн музейнүүд болон компакт диск болон интернэт сайтад тавигдсан үзмэрүүд багтана.

Б. Тоглолт, баяр ёслол

Тоглолт, баяр ёслол-д шууд зохион байгуулж байгаа соёлын бүх арга хэмжээ багтана.

Урлагийн тоглолт нь театр, бүжиг, дуурийн жүжиг, хүүхэлдэйн театр зэрэг мэргэжлийн болоод уран сайханчдын үйл ажиллагааг хамарна. Түүнээс гадна орон нутагт зохиогдож буй албан бус *наадам, баяр ёслол, яармаг* зэрэг соёлын үйл ажиллагаа энэ ангилалд багтана.

Хөгжим нь хэлбэрээс үл хамааран уг салбарт бүхлээрээ тодорхойлогдоно. Үүнд амьд хөгжим, хөгжмийн тоглолтын бичлэг, хөгжмийн зохиол, хөгжмийн бичлэг, дижитал хөгжим (үүнд хөгжмийн татан авалт болон байршуулалт багтана), хөгжмийн зэмсгүүд хамаарна.

В. Визуал урлаг ба гар урлал

Визуал урлаг гэдэг нь уг чанараараа харах үзэх байдлаар бүтээгдсэн уран сайхны бүх хэлбэрийг хэлнэ. Тэдгээр нь харж хүртэхэд зориулагдсан бөгөөд янз бүрийн хэлбэртэй байж болно. Орчин үед дүрслэх урлагийн төрлүүдэд урлаг хоорондын хэлбэрүүд болох “виртуал урлаг” гэгдэх хэлбэрийг багтдаг ч эдгээр нь *аудио-визуал болон интерактив медиа хэрэгсэл* болох Д салбарт хамаарна.

Визуал урлаг, гар урлалын салбар нь уран зураг, зураасан зураг, уран баримал, зэрэг дүрслэх урлаг, *уран сайхны гар урлал болон фото зургийг* багтаана. Энэ салбарт урлагийн бүтээлүүдийг дэлгэн үзүүлдэг байр болох арилжааны уран зургийн галерей багтана.

ССХ-д олон улсын худалдааны төв болон ЮНЕСКО-гоос гар урлал эсвэл гараар урлах бүтээгдэхүүний тодорхойлолтыг “гараар буюу гар багажаар, эсвэл механик хэрэгслийн тусламжтай хийсэн гар урлалын зүйлс байх бөгөөд эцсийн бүтээгдэхүүний гол зонхилох хэсэг нь гар аргаар бүтээгдсэн байна” гэжээ. Гар урлалын бүтээгдэхүүн нь соёлтой холбоотой хэрэглээний, гоо зүйн уран сайхны, бүтээлч зэрэг онцлох шинж чанартай, чимэглэлийн, ямар нэг үйл ажилд хэрэглэх зориулалттай, уламжлалт, шашны буюу нийгмийн бэлгэдлийн болон ач холбогдолтой зэрэг шинжтэй байх ёстой (ЮНЕСКО, ИТС, 1997).

Гар урлалын бүтээлийг (ЮНЕСКО, ИТС, 1997)-гоос бүтээгдэхүүний материалыг нь үндэслэн 6 том хэсэгт хуваасан байна. Үүнд: сагс/сүлжмэл/ургамлын мяндсан сав, арьсан эд зүйлс, металл эдлэл, вааран эдлэл, хөвөн даавуун болон модон эд зүйлс оржээ. Түүнчлэн тухайн хэсэгт онцгой, ховор тодорхой бүс нутгаас олборлодог эсвэл боловсруулахад бэрх чулуу, шил, зааны яс, яс, хясаа, дун зэрэг гар урлалын эд зүйлсийг багтаасан нэмэлт ангиллуудыг оруулсан байна. Түүнчлэн нэмэлт ангилалд нэгэн зэрэг өөр өөр материал, технологи ашиглан хийдэг чимэглэл, үнэт эдлэл, хөгжмийн зэмсэг, тоглоом болон урлагийн бусад бүтээлүүдийг оруулсан байна. Уран сайхны олон бүтээл үйлдвэрлэлийн аргаар хийгддэг ч ССХ-нд уламжлалт шинж чанартай бүтээгдэхүүнүүдийг (хээ, угалз технологи буюу материал) ССХ-ний нэг хэсэг гэж үзсэн байна. Орчин үеийн уран сайхны урлалыг *визуал урлаг болон гар урлал* гэсэн ангилалд бус Е буюу *Загвар, бүтээлч үйлчилгээ*-ний салбарт оруулсан байна.

Г.Ном, хэвлэл

Энэ ангилалд *ном, сонин, тогтмол хэвлэл* зэрэг хэвлэлийн бүх төрлүүд багтана. Энэ нь 1986 оны ССХ-д (ЮНЕСКО, 1986) хэвээрээ үлдсэн ч үүн дээр онлайн сонин хэвлэл, цахим ном, ном болон хэвлэлийн материалын дижитал түгээлт нэмэгдсэн. Түүнчлэн уг салбарын *номын яармаг худалдаа* гэсэн ангилалд бодит ба виртуал номын сангууд хамаарна.

Хэвлэл өөрөө соёлын үйл ажиллагаа биш бөгөөд ерөнхийдөө соёлын ангилал, бүтээлч салбарт хамрагддаггүй, Гэлээ ч үйлдвэрлэлийн мөчлөгийн загварыг хэрэглэх явцад хэвлэлийн үйл ажиллагааны үйлдвэрлэлийн үүрэг гэж ангилагдаж болно. Иймээс ССХ-д соёлын зориулалттай эцсийн бүтээгдэхүүний хэрэглээний хэсэгт оруулсан болно. Одоо хэрэглэж байгаа статистикийн ангиллаар хэвлэлийн үйл ажиллагааны эдгээр төрлүүдийн ялгааг гаргахад хүндрэлтэй байгаа. Хэвлэл ерөнхийдөө үйлдвэрлэлийн үүргийн байдлаараа *ном, хэвлэл* гэсэн үндсэн хэсэгт хамрагддаг ч арилжааны болон техник ашиглалтын каталоги бизнесийн түргэн хэвлэл зэрэг утгаараа *бусад хэвлэмэл зүйлсийг* хассан байгаа. ССХ-д эдгээр холбогдох хэвлэлийн үйл ажиллагаануудыг тоног төхөөрөмж, дагалдах материал гэсэн бүлэгт ангилсан болно.

Д. Аудио-визуал ба интерактив мэдээллийн хэрэгслүүд

Энэ салбарын үндсэн элементүүд *радио, телевизийн нэвтрүүлэг* бөгөөд үүнд интернэтийн шууд нэвтрүүлэг, *кино ба видео, интерактив мэдээллийн хэрэгслүүд* багтана. *Интерактив мэдээллийн хэрэгсэл* нь видео тоглоом, голцуу вэб болон компьютерээр дамждаг соёлын шинэ илэрхийллүүд юм. Эдгээрт Facebook гэх зэрэг олон нийтийн сүлжээтэй холбоотой сайтуудын онлайн тоглоом, вэб портал, вэбсайтын үйл ажиллагаа болон You Tube зэрэг интернэт файл түгээгчсайт зэрэг багтана. Гэхдээ интернэт компьютерийн програм хангамж нь дэд бүтэц, тоног төхөөрөмжид хамаардаг тул интерактив хэрэгслийн бүтээгдэхүүнийг холбогдох салбар буюу *тоног төхөөрөмж, дагалдах материал* гэсэн салбарт багтаах хэрэгтэй юм.

Интерактив мэдээллийн хэрэгсэл, програм хангамж нь үйл ажиллагааны чухал салбар юм. Интерактив мэдээллийн хэрэгслийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь (компьютер болон видео тоглоом, интерактив вэб, хөдөлгөөнт агуулга) соёлын агуулгатай байдаг бол програм хангамжийг ингэж ангилах боломжгүй юм. ССХ-д *интерактив хэрэгсэл*-ийг *аудио-визуал ба интерактив мэдээллийн хэрэгсэл* гэсэн салбарт хамааруулсан. Амьдрал дээр энэ нь ашиглагдаж буй ангиллын системийн интерактив мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг програм хангамж, телевизийн харилцаа холбооны үндсэн үйл ажиллагаанаас нарийвчлан тусгаарлах чадвартай холбоотой. Үндсэн бүтээгдэхүүний ангилал (ҮБА) нь интерактив мэдээллийн бүх үйл ажиллагааг бус харин зарим үйл ажиллагааг тодорхойлох боломжтой. ҮБА болон бусад ангиллын хүрээнд үйл ажиллагааг хэрэв тусад нь ангилах боломжгүй бол холбогдох салбар болох *тоног төхөөрөмж ба дагалдах материал* гэсэн бүлэгт ангилах нь зүйтэй.

Интерактив мэдээллийн хэрэгслүүд дараах тохиолдлуудад интерактив гэж тооцогдоно. Үүнд: (1) хоёр ба түүнээс дээш объект харилцан бие биедээ нөлөөлөх; (2) хэрэглэгч объектод буюу байгаа орчныхоо хүрээнд нөлөөлөх (хэрэглэгчид видео тоглоом тоглох); (3) тэд хэрэглэгчийг идэвхтэй оролцуулахад; (4) нэг талын нөлөөллийн оронд хоёр талын харилцан нөлөөлөл гарч ирэх буюу холбоо харилцааны энгийн шалтгаан үр дагавар зэрэг багтана (Канадын өв, 2008).

Видео тоглоом болон тэдгээрийн боловсруулалт нь (програм хангамжийн дизайн) интерактив үйл ажиллагаа тул энэ салбарт ангилагдана.

Е. Загвар ба бүтээлч үйлчилгээ

1986 оны ССХ-д *загвар ба бүтээлч үйлчилгээ* гэсэн салбар тусгагдаагүй байсан (ЮНЕСКО, 1986). Энэ салбар нь барилга байгууламж, байгалийн үзэсгэлэнт газар, эд зүйлсийн бүтээлч, уран сайхны, гоо зүйн, загварын үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүнүүдийг бүгдийг нь хамарна.

Уг салбарт *хувцасны загвар, график болон дотоод засал чимэглэлийн дизайн, байгалийн үзэсгэлэнт газрын загвар, архитектурын болоод зар сурталчилгааны үйлчилгээ* зэрэг багтана. *Уран барилга болон зар сурталчилгаа* нь соёлын үндсэн салбарын хэсэг ч гэсэн зөвхөн үйлчилгээний шинж чанартай. Уран барилга, зар сурталчилгааны гол зорилго нь бүтээлч үйлчилгээ үзүүлэх, эсвэл эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд завсрын оролцоо үзүүлэхэд оршдог тул эцсийн бүтээгдэхүүн нь шинж чанарын хувьд соёлын байж чаддаггүй. Жишээ нь: бүтээлч зар сурталчилгаа хийх үйлчилгээний эцсийн бүтээгдэхүүн нь ашгийн төлөө байдаг тул соёлын шинж чанартай биш ч бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болдог. Давхардуулж тоолуулахгүйн тулд загвар дизайны зарим үйл ажиллагааг Е-с бусад ангилалд хамааруулсан. Жишээ нь: соёлын өвд хамаарах бүх барилга байгууламжуудыг *соёлын ба байгалийн* өв гэсэн А хэсэгт ангилсан бол интерактив мэдээллийн хэрэгслийг *аудио болон интерактив мэдээллийн хэрэгсэл* гэсэн Д хэсэгт хамааруулсан байна.

Нийтлэг хамааралтай салбарууд

Энэ салбарыг бие даасан салбар гэж ангилж болох ч соёлын бусад бүх салбарт бүрэн үйлчилдэг тул *нийтлэг* гэж нэрийдсэн болно.

Биет бус соёлын өвийн салбарыг соёлын гэж авч үздэг салбар тухайлбал *архив ба хадгалалт, боловсрол ба сургалт, тоног төхөөрөмж ба дагалдах материал хэрэгсэл* соёлтой хамааралтай үйл ажиллагаа, элементүүдийг агуулдаг тул соёл болоод ССХ-ний хувьд сонирхол татахуйц, чухал ач холбогдолтой юм.

Биет бус соёлын өв (Нийтлэг хамааралтай салбар)

Биет бус соёлын өвийг хамгаалах ЮНЕСКО-гийн конвенци нь (ЮНЕСКО, 2003b) үүнийг тодорхойлохдоо: “Биет бус соёлын өв (ББСӨ)гэдэг нь ард иргэд, бүлэг зарим тохиолдолд хувь хүмүүс соёлын өвийнхөө нэг бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, ойлголт, мэдлэг болон дадал чадвар, эдгээртэй холбоотой багаж зэмсэг, эд зүйлс, урлагийн бүтээлүүд түүнчлэн соёлын орон зай юм” гэжээ (2-р зүйл).

Биет бус соёлын өв нь уламжлал болон орчин үед нэгэн зэрэг оршин байдаг. “ББСӨ нь үеэс үед дамжин уламжлагдаж, хүрээлэн буй орчин, байгаль, түүхийн харилцан нөлөөнд сэргээгдэж бүхэл бүтэн болон өвөрмөц чанараа хадгалдаг” (2-р зүйл).

ББСӨ-ийн давтагдашгүй өвөрмөц шинж нь ард иргэд түүнийг өөрийн соёлын өвийн нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрснөөр тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, хөндлөнгийн этгээд (засгийн газар, статистикч, судлаачид) илрэх хэлбэр болоод амьдрал дээр тэдгээрийг биет бус соёлын өв гэж тодорхойлох боломжгүй. Иймээс ББСӨ-ийн тодорхойлолт нь тэдгээрийг хадгалж, дамжуулж, бүтээж буй ард иргэд, бүлгүүд зохистой гэж үзвэл хувь хүний онцгой эрхийн асуудал болон үлддэг.

ББСӨ-ийг соёлын үйл ажиллагааны эсвэл үйлдвэрлэлийн тусдаа салангид салбар гэж үзэж болохгүй ч бүх салбаруудад тусгалаа олсон байдаг. Жишээ нь: биет бус соёлын өв нь уран сайхны үйл ажиллагаа, урлагийн тоглолтын хэлбэрээр илэрч болно. Иймээс соёлын нийтлэг хамааралтай салбар байдлаар тусгагдсан (Зураг 2-ыг хар). ББСӨ-ийн бүрэн бус салбарт дараах зүйлсийг багтаажээ. Үүнд: а) *биет бус соёлын өвийн дамжуулагч хэрэгсэл болох хэлийг оролцуулан аман уламжлал, илэрхийлэл; б) урлагийн тоглолт; в) нийгмийн дадал, зан үйл, баяр ёслолын үйл ажиллагаанууд; г) байгаль, дэлхий ертөнцтэй холбоотой мэдлэг, практик; д) уламжлалт гар урлал зэрэг* багтана.

Биет бус соёлын өвийн энэхүү шинэ ангиллыг боловсруулахад ЮНЕСКО-гийн зүгээс салбарын үүрэг, үнэ цэнийн талаар олон жилийн судалгаа хийсэн юм. Эдгээр нь соёлын өвийг ойлгож, хамгаалж, хүндлэх шинэ хандлагыг бий болгоход хувь нэмэр болж ББСӨ-ийг тээгч, дамжуулагч, хэрэгжүүлэгч нар хүлээн зөвшөөрсөн юм.

Архив, хадгалалт (Нийтлэг хамааралтай салбар)

Архивлах гэдэг нь соёлын хэлбэрүүдийг (хөдөлгөөнт биетүүд болон биет бус юмс) хойч үедээ хадгалан үлдээх, үзүүлэх, дахин ашиглах зорилгоор цуглуулан хадгалахыг (түүхэн дурсгалт газар, барилга байгууламжууд, дуу авианы архив, зургийн сан гэх зэрэг) хэлнэ. *Хадгалалт* нь тодорхой соёлын болон байгалийн дурсгалт эд зүйлсийг хамгаалж, хадгалж, хянан зохион байгуулахтай холбоотой.

Архивлах ба хадгалах үйл ажиллагаа нь соёлын бүх салбарт байна (зохиогчийн гар бичмэл, тухайн бүтээлийн анхны тоглолт, концерт, үзэсгэлэнгийн хөтөлбөр г.м). Архивын материал нь шинэ уран бүтээл гаргах урам зоригийг өгөх лавлах материал ч болдог. Уран зураг, гар урлал, загвар, архитектур, хэвлэл нийтлэл болон аудио-визуал салбаруудын архив, хадгалалт нь шинэ бүтээлийн бүтээлч санааг бий болгоход нөлөөлж болдог. Жишээ нь: түүхэн барилга байгууламжийн архитектурыг хадгалж хамгаалах (мөн үзмэр), уран зургийн галерей болон музейд тавьсан (мөн үзмэр) уран зураг, уран баримал, гоёл чимэглэлийн зүйлс болон ур хийцийн жижиг хэсгүүдэд үнэ цэнэ нь оршдог бусад өргөн хүрээний түүхэн дурсгалт зүйлс (гэрийн тавилгаас эхлээд автомашин гэх зэрэг юм бүхэн багтана) багтах бол архивт гар бичмэл, фото зураг, ном, кино, радио бичлэг гэх зэргийг хадгалдаг.

Боловсрол ба сургалт (Нийтлэг хамааралтай салбар)

Соёлын статистикийн хүрээ нь *боловсролыг* бүхэлд нь авч үзээгүй бөгөөд зөвхөн соёлын үнэ цэнэтэй зүйлс, соёлын ур чадварыг дамжуулах хэрэгслийнх нь хувьд үүнийг авч үздэг. Сургах үйл ажиллагаа нь соёлыг хөгжүүлэх, ойлгуулах, хүртээх үйл явц, бүр шүүмжлэлийг (уран сайхны болон бүжгийн сургууль, уран зохиолын шүүмжлэл гэх зэрэг) хүртэл дэмждэг. Боловсрол бол уламжлалыг үеэс үед дамжуулах үйл явц юм. Түүнчлэн хүмүүс соёлын үйл ажиллагаа, бүтээлийг үнэлж, цэгнэж (шүүмжлэл гэх зэрэг) сурна гэсэн үг юм. Боловсрол гэдэг нь соёлыг ухамсарлан ойлгох, одоо байгаа соёлын хэм хэмжээг шүүн тунгаах бүтээлч эхлэлийг тавих, бүтээлч эхлэлийг хөгжүүлэх нийгэмшлийн үйл явц юм.

Соёлын *боловсрол, сургалт* нь хүмүүсийг соёлын бүтээгдэхүүнийг бүтээж, бий болгох ур чадварыг эзэмшихэд тусалдаг. Энэ нь хүмүүсийг соёлын үйл ажиллагаанд оролцож нийгмийн сайн сайхны баялаг болон үйлчилгээг хүртэх, соёлын амьдралд оролцож нийгмийн давуу байдал эдлэхийн үр дүнг үнэлж цэгнэхэд сургадаг. Боловсрол нь нийгмийн бүлгүүдийн өвөрмөц ялгаатай шинж чанарыг бүрдүүлдэг албан ба албан бус соёлын өвийг дамжуулах үүрэг хүлээдэг. Ийнхүү боловсрол, сургалт нь соёлын бүх салбар, соёлын мөчлөгийн бүх үе шатанд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Боловсролын хувьсах хэмжигдэхүүнийг хэрэглэх явцдаа улс орнууд олон улсын боловсролын стандарт ангилал (ОУБСА97), (ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэн, 2006d)-г ашиглаж мэдээлэл цуглуулах буюу олон улсын хэмжээнд харьцуулах боломжтой байхын тулд мэдээллийг боловсруулахдаа ОУБСА 97-д заасан ангиллын системүүдийг хэрэглэхийг зөвлөж байна. Түүнчлэн улс орнууд ОУБСА 97-н бүтцийг ашиглавал зохино.

Тоног төхөөрөмж, дагалдах материалууд (нийтлэг хамааралтай салбар)

Энэхүү салбар нь “соёлын бүтээгдэхүүн болон соёлын үйл ажиллагааны хэрэгслийг” хамардаг. Янз бүрийн салбар дахь соёлын бүтээгдэхүүн нь (бүтээгдэхүүн, үйлчилгээ) соёлын агуулгатай хамаатай бөгөөд үүний зэрэгцээ тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл нь соёлын бүтээгдэхүүнийг бүтээн бий болгох, түгээн тараадаг (агуулгын хувьд зарим талаараа соёлын байлаа ч) боломжийг бүрдүүлдэг, дэмждэг дагалдах салбар, нэмэлт үйлчилгээ үзүүлдэг тул энэ салбарт хамаарна. Эдгээр нь интернэтийн олон бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэн тараадаг хэрэгсэл болдог бөгөөд интерактив мэдээллийн хэрэгслийг хөгжүүлдэг тул энэ ангилалд компьютер мэдээллийн технологийг хамааруулсан.

Эдгээр нь бүхэлдээ соёлын салбарт хамаардаггүй боловч соёлын салбарын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, амьдралд хэрэгжүүлэхэд элементүүдийг нь тодорхойлох шаардлагатай бөгөөд соёлын эдгээр бүтээгдэхүүн оршин байхад эдгээр нь зайлшгүй шаардлагатай тул А-F салбарт хамруулсан бүтээгдэхүүн, үйл ажиллагаанаас уг ангилал ялгаатай байгаа юм.

Соёлын талаарх судалгаа шинжилгээ нь хамаарах салбар бүрийн зохих ангилалд тусгагдсан болно.

Холбогдох салбарууд

Спорт, чөлөөт цаг, аялал жуулчлалд соёлын элементүүд байдаг ч эдгээрийг соёлын үйл ажиллагаа гэж тэр бүр авч үздэггүй. Өөрөөр хэлбэл эдгээр үйл ажиллагаанууд соёлын шинжтэй байж болох ч тэдгээрийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд нь соёлын бус байдаг. Иймээс эдгээрийг ССХ-д *Холбогдох салбарууд* гэж оруулсан байна.

Ж. Аялал жуулчлал

Тодорхой зах зээл эсвэл үйлдвэрлэлийн аль нэгээр хэмжигддэг тул аялал жуулчлал нь соёлын бусад салбаруудаас чанарын ялгаатай бөгөөд уламжлалт утгаар нь салбар гэж ангилах боломжгүй. Аялал жуулчлалыг хэрэглэгчдийн тодорхойлсон үйл ажиллагаа, эрэлт хэрэгцээгээр үүссэн үйл ажиллагаа гэж ойлгогддог ч энэ чанараараа соёлын үйлдвэрлэлийн хүрээний бусад салбартай холбоотой бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг жуулчид гүйцэтгэдэг. Иймд орчин үед аялал жуулчлалын дагалдах тайланд тулгуурласан аялал жуулчлалын эдийн засгийн үр нөлөөг хэмжихэд зориулсан сайтар боловсруулагдсан олон улсын арга зүй байгаа юм (Eurostat.OECD.UN болон UNWTO 2001 зэргийг үз).

Эцсийн дүнд ССХ нь аялал жуулчлалыг *соёлын аялал жуулчлал, оюун санааны аялал жуулчлал, эко аялал жуулчлалтай* холбоотой үйл ажиллагаа гэж авч үзэн соёлын үзүүлэлтүүдийг тооцох ёстой юм. Хэдийгээр соёлын аялал жуулчлалын тодорхойлолтын хувьд олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт байдаггүй ч ССХ нь дараах зүйлийг төлөвлөж байна. Үүнд: “бусад соёл, газар нутгийн ард түмэн, амьдралын хэв маяг, өв болон урлагтай илүү танилцсанаар тэдний түүхэн хөгжил, оршин буй ялгаатай нь газар дээр нь танилцах тусгай аялал” гэж тодорхойлжээ (Штайнберг К. 2001). Энэ нь *оюун санааны* болон *эко аялал жуулчлалын* хэлбэртэй байж болно. Энэхүү үйл ажиллагаа нь соёлын салбарын А, Б, В салбар эсвэл биет бус соёлын өвд хамаарна. Жишээ нь: жуулчин эртний соёл иргэншлийн дурсгал болон концерт үзвэл энэ нь шууд л тухайн соёлын салбарт багтана гэсэн үг.

Соёлын дагалдах тайлангийн аргачлалд тулгуурлаж гаргасан аялал жуулчлалын статистик нь жуулчдын бараа, үйлчилгээний (олон улсын болон дотоодын) эрэлт хэрэгцээг хэмждэг. Үүнд аян зам, орон байр, болон бусад зардал багтана. Гэхдээ статистик нь мөнгөтэй холбоогүй мэдээлэл буюу жуулчдын тоо, аяллын зорилго зэргийн талаарх мэдээллийг багтаах ёстой. Иймээс давхардуулан тооцохгүйн тулд аялал жуулчлал нь энэ салбарт ангилагдах бөгөөд (жишээ нь: жуулчдын хөтөч болон аяллын оператор компаниуд г.м) жуулчдын үйл ажиллагааны үндсэн объект болсон (жишээ нь: байрлах газар) соёлын үйлдвэрлэлийн гаднах үйл ажиллагаанд хамаарна.

3. Спорт, чөлөөт цаг

Спорт

Спортыг ССХ-д илүү өргөн ойлголтоор авч үздэг нь зохион байгуулалттай болон өрсөлдөөнт спорт түүнчлэн бие бялдрын чийрэгжүүлэлт, *эрүүл мэндийн* болон *биеийн тамиртай* холбоотой чөлөөт цаг багтдагт оршино. ССХ-д сонирхогчдын болон мэргэжлийн спорт тусгагдсан байдаг.

Спорт нь нийгмийн бүтэц болон уламжлалтай холбоотой байж болох тул зарим орны хувьд спортын төрлүүд нь тэдний соёлын өөрийн өвөрмөц шинжтэй нягт холбоотой байдаг. Үүний нэг жишээ нь Японы сумо бөхийн барилдаан юм. Бусад орнуудад спортыг чөлөөт цагийн идэвхтэй хэлбэр буюу ихэнх тохиолдолд биеийн тамирын дасгалуудыг бодвол спортоор илүү идэвхтэй хичээллэхээс хэтэрдэггүй. Түүнчлэн ижил спортын төрлүүдийг орон оронд өөрөөр холбож хүлээн авдаг. Зарим ангилалд (Европын Хороо, 2002) үзэгчид спортын тэмцээн үзэх болон телевизээр спортын уралдаан тэмцээн үзэхийг соёлын үйл ажиллагаа гэж тооцдог атлаа мэргэжлийн спортыг соёлд заавал хамаатай гэж үздэггүй байна. Хандлага чиглэлийн энэхүү чухал ялгаа болон спортын бус оролцоог “соёлын салбар эсвэл бүтээгдэхүүн” гэж үздэг нэлээд дэлгэрсэн ойлголт нь биднийг спортыг холбогдох салбарт ангилахад хүргэсэн юм.

Чөлөөт цаг

Чөлөөт цагийг энэ салбарт хамааруулахдаа үүнийг таашаал өгч, амрахтай холбоотой зугаа цэнгэл, шинэ сэтгэгдэл төрүүлэх үйл ажиллагаа гэж тодорхойлсон юм. Эдгээрт мөрийтэй тоглоом, тоглоом үзүүлбэр бүхий амралтын хүрээлэн, тоглоомон дээр тоглох болон бусад чөлөөт цагийн хэлбэрүүд багтана. Гэхдээ *спортод* хамаатай биеийн тамирын бүх хэлбэрийг оруулаагүй.

Бооцоот тоглоом

Бооцоот тоглоомуудад гол төлөв казино, морин уралдаан зохион байгуулагчдын албан байр, лото болон автомат тоглоомын газрууд, сугалааны товчоо, морин уралдааны талбайн гаднах тоолуур зэрэг байгууллагууд хамаарна (ABS , 2001).

Сугалаа нь Англи зэрэг зарим оронд соёлын салбарыг санхүүжүүлэх томоохон эх сурвалж болдог. Бооцоот тоглоомыг холбогдох салбарт бус ССХ-ний нэг хэсэгт хамруулсны учир нь үүнд оршино.

Соёл амралт, тоглоомын парк

Энэ үйл ажиллагаанд тоглоом үзүүлбэр бүхий соёл амралтын хүрээлэн болон бусад бүх төрлийн тоглоомууд багтана.

3. Соёлын статистик: Эдийн засгийн үзүүлэлтийг хэмжих нь

Энэ бүлэг нь одоо хэрэглэгдэж байгаа олон улсын ангиллын системийг ашиглан соёлын үйл ажиллагааны эдийн засгийн үзүүлэлтийг хэрхэн хэмжих аргыг нээж өгнө. ССХ-д багтсан соёлын эдийн засгийн аспектиуд нь үйлдвэрлэлийн болон гар аргаар салбар бүрээр бүтээн бий болгосон бүтээгдэхүүн, үйлчилгээний бүх төрлийг хамарсан болно. Энэхүү хандлагын үр дүнг соёлын үйл ажиллагаа, бараа, үйлчилгээ болон ажил эрхлэлтийн соёлын мөчлөгийн үүрэгтэй холбоотой ангиллуудын тодорхойлолтоор дамжуулан илрүүлэх боломжтой. Үүнийг бүх ангиллын дагуу чухалд тооцсон ангилал бүрээр жагсаалт гаргасан 5-р бүлэгт тусгасан болно.

3.1 Соёлын эдийн засгийн үзүүлэлтийн хэмжилтэд олон улсын ангиллыг хэрэглэх нь

Энэхүү бүлэгт одоо байгаа арга хэрэгслийг соёлын статистик мэдээллийг цуглуулахад хэрхэн ашиглах тухай асуудлыг авч үзэх болно. Эдгээр мэдээлэл цуглуулах арга хэрэгслүүд нь соёлын талаарх мэдээ мэдээллийг олон улсын хэмжээнд олж авах, харьцуулан судлах боломж олгодог олон улсын ангиллын системүүдээс бүрдэнэ. Эдгээр олон улсын ангиллын ихэнх нь эдийн засгийн дүн шинжилгээ хийх, бодлого боловсруулах, шийдвэр гаргах чиглэлд зориулагдсан эдийн засгийн тоо баримтыг цуглуулах, хүрээний цогц систем болдог.

Одоо хэрэглэж байгаа захиргааны мэдээлэл болон түүвэр судалгаанууд нь (хувь хүний, бизнес болон өрх) дотоодын нийт бүтээгдэхүүн болон соёлын салбарын ажил эрхлэлт, соёлын хэрэглээний хувьд үндэсний эдийн засагт соёлын оруулах хувь нэмрийг хэмжиж дүгнэхэд тус болох өргөн хэмжээний мэдээлэл боловсруулахад ашиглаж болно. Соёлын бүтээгдэхүүн болон ажил эрхлэлтийн талаарх эдийн засгийн мэдээллийг олон улсын статистикийн ангиллын системийн дагуу одоо байгаа эдийн засгийн судалгаанаас эдийн засгийн ерөнхий статистикийг нэгтгэн үндэсний статистикийн хорооноос гаргадаг (5-р хэсгийг харах). Мэдээллийг ерөнхийдөө бизнес, аж ахуйн нэгжийн судалгаа, өрхийн зарлагын судалгаа, бизнесийн бүртгэл, цалин орлогын судалгаа, ажиллах хүчний судалгаа, хүн амын тооллого зэргээс цуглуулдаг. Хэдийгээр эдгээр мэдээлэл цуглуулах хэрэгслүүд нь соёлын талаарх мэдээлэл цуглуулахад тусгайлан зориулагдаагүй боловч соёлын сонгосон төрлүүд болон холбогдох үйл ажиллагааг шинжлэн судлах боломж олгож болно.

Энэ бүлэгт эдийн засгийн 4 ангиллын хэрэглээг багтаасан болно. Дэлгэрэнгүй жагсаалтыг тус баримт бичгийн 5-р бүлэгт үзүүлэв. Эдгээр нь:

- i) Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллыг (ЭЗБТҮАСА 4) соёлын бүтээлч үйл ажиллагаа буюу салбаруудын үйл ажиллагааг тодорхойлоход хэрэглэх (5-р бүлэг, 2-р хүснэгт).
- ii) Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангиллыг (БҮНА 2) соёлын салбарын бараа, үйлчилгээг тодорхойлоход хэрэглэх (5-р бүлэг, 2-р хүснэгт).
- iii) Бараа бүтээгдэхүүнийг тодорхойлох, кодлох уялдаат систем 2007 (УС 2007), (5-р бүлэг, 3-р хүснэгт) болон Төлбөрийн тэнцлийн (ТТ)үйлчилгээний өргөтгөсөн ангиллыг (3-р бүлэг, 1-р хүснэгт) соёлын бараа, үйлчилгээний олон улсын худалдааг тодорхойлоход.
- iv) Ажил мэргэжлийн олон улсын стандарт ангиллыг (АМОУСА 08) соёлын салбарт ажил эрхлэлтийг тодорхойлоход хэрэглэх зэрэг болно (5-р бүлэг, 1-р хүснэгт).

Үндэсний болон олон улсын түвшний статистик үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах хэрэгсэл буюу судалгаанд эдгээр ангиллын системүүдийг хэрэглэдэг байна. Ерөнхийдөө олон улсын ангиллын систем нь Хойд Америкийн салбарын ангилал, Австрали, Шинэ Зеландын үйлдвэрлэлийн стандарт ангилал, Европын нэгдсэн орнуудын эдийн засгийн үйл ажиллагааны ангилал зэрэг үндэсний болон бүс нутгийн системүүдтэй зохицдог. Хойд Америкийн бүтээгдэхүүний ангиллын систем болон бүтээгдэхүүний үйл ажиллагааны ангиллыг Европын орнуудад бүтээгдэхүүний төрөл зүйлийн ангилалд ашиглаж болох юм. Аль ч хоёр ангиллын хооронд холбоос үүсгэж зохицуулахын тулд харилцан хамаарлын хүснэгтүүдийг ашиглах нь зүйтэй¹.

Өөр нэг өргөн хэрэглэгддэг эдийн засгийн загвар бол Үндэсний тооцооны систем юм. Үндэсний тооцооны систем⁰⁸ нь Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал (БҮНА) болон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ЭЗБТУАСА) 2-той тохирдог. Түүнчлэн удирдах байгууллагын үүргийн ангилал, хувийн аж ахуйн зорилгоор нь нэг бүрчлэн ангилах, Арилжааны бус байгууллагын зорилгын ангилал зэргийг ашигладаг. Эдгээр ангиллуудыг ашиглан үйл ажиллагааг нь тодорхойлогддог соёлын үйл ажиллагааны төрлүүдийг дор жагсаав. Үүнд:

- а) Засгийн газрын үүргийн ангиллыг (ЗГҮА) улсаас соёлд зарцуулсан зардлыг үнэлэхэд хэрэглэдэг. Соёлын үндсэн ангиллуудыг дараах байдлаар ангилсан байна. Үүнд:

08.1.0-Спорт, зугаа цэнгэлийн салбарын үйлчилгээ
08.2.0-Соёлын үйлчилгээ
08.3.0-Радио телевизийн нэвтрүүлэг, хэвлэл нийтлэлийн үйлчилгээ
08.5.0-Чөлөөт цаг, соёл, шашны салбарын судалгаа, боловсруулалт
08.6.0-Бусад хэсэгт ангилагдаагүй чөлөөт цаг, шашин шүтлэг, соёл

- б) Хувийн аж ахуйг зорилгоор нь нэг бүрчлэн ангилах систем нь дараах ангиллуудаар соёлыг ангилдаг. Үүнд:

13 – Өрхөд үйлчилдэг ашгийн төлөө бус байгууллагын хувийн хэрэглээний зарцуулалт
13.3 – Амралт зугаа цэнгэл ба соёл
14 – Төвлөрсөн удирдлага засаглалын хувийн хэрэглээний зарцуулалт
14.3 – Амралт зугаа цэнгэл, соёл .

- в) Соёлтой холбоотой арилжааны бус байгууллагын ангилалд:

03 – Амралт зугаа цэнгэл, соёл
03.1 – Спорт, амралт зугаа цэнгэлийн үйлчилгээ
03.2 – Соёлын үйлчилгээ.

¹ Ангилал болон харилцан хамаарлын хүснэгтүүдийг UNSD-н ангиллын бүртгэл болон Европын RAMON сайтаас үзэх боломжтой (http://ec.europa.eu/eurostat/ramon/index.cfm?TargetUrl=DSP_PUB_WELC)

Зөвхөн дээр дурдсан ангиллууд болон Үндэсний тооцооны системийн мэдээ баримтаар соёлыг үнэлэх нь түүний эдийн засагт оруулах хувь нэмрийг дутуу үнэлэхэд хүргэнэ гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь Чили, Колумб зэрэг хэд хэдэн улс орон *соёлын дагалдах тайлан* боловсруулж эхэлж байгаагийн нэг шалтгаан юм. Жишээ нь: Колумб болон Латин Америкийн хэд хэдэн оронд ажилладаг Convenio Andrés Bello (CAB) олон улсын засгийн газар хоорондын байгууллага нь соёлын дагалдах тайланг хэрэгжүүлэх аргачлалыг боловсруулаад байна. Дагалдах тайлан нь соёлын үйлдвэрлэл, үйл ажиллагааны дотоодын нийт бүтээгдэхүүнд оруулах эдийн засгийн хувь нэмрийг үнэлж дүгнэхэд тустай. Энэхүү аргачлал нь соёлын салбар дахь арилжааны бус бүтээгдэхүүн, үйл ажиллагааг дүгнэн тооцоход онцгой хүндрэл учруулдаг. Соёлын статистикийн хүрээ нь тодорхой ангиллын тухайлбал эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ЭЗБТУАСА) болон ажил мэргэжлийн олон улсын стандарт ангиллыг дэмжих замаар үндэсний дагалдах тайланг хөгжүүлэн боловсруулах ойлголтын загвар болж болно. Энэ арга хандлага нь нягтлан бодох бүртгэлийн аргачлалын тусламжтайгаар соёлын талаар санхүүгийн илүү тодорхой үнэлгээ гаргах боломж олгож байгаа юм. Нөгөөтэйгүүр одоогийн хамрах хүрээ нь зөвхөн эдийн засгийн үр нөлөөнд анхаардаг дагалдах тайлантай харьцуулбал соёлын үйл ажиллагаа, түүний үзүүлэх нөлөөний талаар илүү өргөн хүрээтэй ханддаг.

3.2 Соёлын бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тодорхойлох нь: Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал (БҮНА) болон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллыг (ЭЗБТУАСА) ашиглах нь

Энэхүү бүлэгт Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал 2 болон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4-ийг хэрхэн ашиглаж бүтээлч соёлын үйл ажиллагааг тодорхойлох талаар авч үзнэ. Энэ нь үндсэндээ үйлдвэрлэлийн мөчлөгийн бүтээх, үйлдвэрлэх, тараах, үзүүлэх, (хүртэх) дамжуулах гэсэн эхний дөрвөн шат дамжлага юм.

Хэрэглээ буюу оролцооны үе шат нь янз бүрийн статистикийн хэрэгслээр илэрхийлэгдсэн бөгөөд 4-р бүлэгт гарах нийгэм эдийн засгийн зан үйлийг тусгасан. Жишээ нь: Соёлын бүтээгдэхүүнийг улсын байгууллага, сайн дурынхан, сонирхогчид болон тусгай жүжигчид, уран бүтээлчид оролцсон хэд хэдэн үйлдвэрлэгчид арилжааны бус зорилгоор бүтээж болно.

Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангиллыг төдийлөн өргөн хэрэглэгддэггүй ч эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилалтай түүнийг нарийвчлан холбосноор үйлдвэрлэлийн салбарууд болон соёлын бүтээгдэхүүнийг илүү тод илрүүлэн харьцуулах боломжтой болно (5-р бүлгийн 2-р хүснэгтийг харах). Энэ нь үйлчилгээний мэдээ баримттай илүү холбоотой. БҮНА-ын гол зорилго нь бүтээгдэхүүнтэй холбоотой одоо байгаа ангиллын системийг хөгжүүлэхийн тулд хянаж шинэчилснээр тэдгээрийг олон улсын стандарттай харьцуулах боломж олгохуйц олон улсын харьцуулалтын систем бүтээн бий болгож, олон улсын стандарттай нийцүүлэхэд оршино. Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал нь бүтээгдэхүүн үйлчилгээний ангиллыг хэрэглэх зохицлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн. Зарчмын хувьд эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилалд тусгагдсан байдаг тул бараа, үйлчилгээг БҮНА-р нэг салбарт боловсруулагдах ангиллуудад оруулсан.

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллыг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны стандарт ангилал болгохыг зорьдог. Үүний үндсэн зорилго нь эдгээр үйл ажиллагаануудын дагуу мэдээ цуглуулж, статистикийг танилцуулах зориулалттай зохих үйл ажиллагааны төрлүүдийн цогц иж бүрдлийг буй болгоход оршино. Иймд эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал нь үйл ажиллагааны цогц иж бүрдлийг хэрэгжүүлж буй эдийн засгийн ажиллагааных нь дагуу ангилах боломж олгохыг эрмэлзэж байгаа юм. Энэ нь олон улсад зөвшөөрөгдсөн ерөнхий ойлголт, тодорхойлолт, зарчим болон ангиллын дүрэмд үндэслэсэн эдийн засгийн үйл ажиллагааны логик уялдаа

холбоотой, дэс дараалалтай ангиллын бүтцээс бүрдэнэ. ЭЗБТУАСА нь эдийн засгийн дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргах, бодлого боловсруулахад зориулагдсан эдийн засгийн тоо баримт цуглуулах, түүнийг мэдээлэх хүрээний иж бүрдэл систем юм (UNSD, 2008).

Ерөнхийдөө бол ЭЗБТУАСА хүрээ нь Үндэсний тайлангийн системийн зааг хүрэн дэх эдийн засгийн үйл ажиллагаанууд гэх зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хамардаг. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг орцыг ашиглаж гарц болгон боловсруулж гаргах ашиглалт гэж тодорхойлдог. Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилалтай харьцуулахад ЭЗБТУАСА-ын нэг давуу тал нь олон улс оронд өргөн ашиглагддаг байдал юм. Гэвч ЭЗБТУАСА нь зөвхөн 4 оронгоор кодлогддог тул БУНА-аас бага нарийвчлалтай тодорхойлогддог тул соёлын зарим төрлүүд далд байдаг бөгөөд энэ нь үйл ажиллагааны илүү өргөн хүрээнд ерөнхий ангилалд хамаарагддаг. Яаж хоёр ангиллын хооронд харилцаа хамаарал үүссэнийг үүгээр тайлбарлах бөгөөд 2-р хүснэгтэд харуулсан болно. Энэ нь соёлын салбарт хамаарах холбогдох салбаруудыг тодруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон холбогдох бүтээгдэхүүнтэй нь холбоотой.

ЭЗБТУАСА болон БУНА-ыг хэрэглэхэд тавигдах хязгаарлалт

Эдгээр ангиллууд нь дээр дурдсанчлан соёлын салбарт тусгайлан зориулагдаагүй ч эдгээрийг соёлын үйл ажиллагаа, бүтээгдэхүүний судалгаанд ашиглаж эхэлж болно.

Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал (БУНА)

БУНА нь 2-р хүснэгтэд жагсаасан татаж авах боломжтой дуу хөгжим, цахим ном зэрэг соёлын шинэ хэлбэрийг ангилахад илүү тохиромжтой. Үүнийг үл харгалзан зарим БУНА-ыг (эсвэл одоо ашиглаж буй өөр ямар нэг олон улсын ангилал) хэрэглэснээр соёлын шинжтэй зарим бараа, үйлчилгээг тодорхойлж болдоггүй. Тухайлбал БУНА-тай харьцуулбал боловсрол, сургалт зэрэг үйл ажиллагаа нь ЭЗБТУАСА 4-р ангилалд (8541 ангилалд *спорт, амралтын боловсрол*, 8542 ангилалд *соёлын боловсрол*д тус тус хамааруулдаг) илүү тодорхойлогддог, ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал 08 (АМОУСА) болон Боловсролын олон улсын стандарт ангиллыг (БОУСА) хэрэглэснээр илүү нарийвчилсан тодорхойлолтыг өгч болно (ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэн, 2006d).

Эдгээр нь БУНА-ын ангиллуудад салган тусгаарлагдах боломжгүй соёлын болон соёлын бус үйл ажиллагааны жишээ юм. Ихэнх тохиолдолд БУНА нь эдгээр ангиллыг соёлын статистикийн хэрэглэнд ашиглахад зориулж багтаадаг ч энэ нь тухайн оршин буй соёлын үнэлгээг хэт өндөрт өргөж болох талтай. Боломжтой бол мэдээлэл хэрэглэгчид бүх ангиллуудын соёлыг бусад соёлын бус төрлүүдээс ялгаж салгахыг зөвлөдөг.

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ЭЗБТУАСА)

ЭЗБТУАСА-ын 4-р хянаж шинэчилсэн хувилбар нь мэдээлэл харилцааны салбарын (2-р хүснэгтийг харах) өнөөгийн байдлыг тусгахын тулд боловсруулагдсан. Энэхүү хувилбар нь радио телевизийн нэвтрүүлэг болон кино урлагийн үйл ажиллагааг бүрэн хамарч байгаа боловч цахим ном болон хөгжим бичилт зэрэг интернэтийн хэрэглээ шаардах тусгай соёлын үйл ажиллагаанд тодорхойлолт өгөх боломжгүй юм.

ЭЗБТУАСА нь зах зээлийн бус үйлчилгээний хэлбэрийг агуулдаг албан ба албан бус үйлдвэрлэл, хууль ёсны болон хууль бус үйлдвэрлэл, зах зээлийн болон зах зээлийн бус үйл ажиллагаануудын хоорондын ялгааг гаргадаггүй. ЭЗБТУАСА нь албан бус салбарын үйл ажиллагааны талаарх мэдээллийг танилцуулах стандартчилсан арга хэрэгсэл болох статистик мэдээллийн тайлан болон судалгаа шинжилгээний альтернатив бүлгийг дэвшүүлэн тавьж байгаа юм (НҮБ, 2008).

Түүнчлэн энэ нь үйлдвэрлэлийн ангилал учраас үйлдвэрлэлийн бус соёлын үйл ажиллагааны хэмжилт үнэлгээг тусгадаггүй. ЭЗБТУАСА-ыг ашиглахад дараах ганц гол дутагдалтай тал байдаг:

“Гар урлал”-ын хувьд бол үйлдвэрлэлийн уламжлалт болон орчин үеийн аргын хоорондын ялгааг гаргаагүйн улмаас гар аргаар хийсэн болон уламжлалт үйлдвэрлэлийг ялгах боломжгүй болгосон.

Соёлын бүх салбаруудад ЭЗБТУАСА-ын дараах 2 ангилал ашиглагддаг. Эдгээрт:

- i) 9000 (*Бүтээлч урлаг ба үзвэр үйлчилгээний үүл ажиллагаа*): энэ ангилал нь ССХ-ний бүх салбартай холбоотой (А-с Е хүртэлх) үйл ажиллагааны өргөн хүрээг хамардаг. Хэрэв зохиогчдын нэгдэл, уран зохиолын дугуйланг хэвлэл нийтлэлийн 581х ангилалд хамруулж болохгүй бол зураачдын хоршоолол, хөгжмийн дөрвөл, томоохон рок хамтлаг зэрэг бизнес хэлбэрээр ихээхэн орлого олдог байгууллагуудын үйл ажиллагаатай адилхан тодорхойлдог.
- ii) 8542 (*Соёлын боловсрол*): энэхүү ангилалд соёлын үйл ажиллагаан дахь дүрслэх урлаг, уран барилга, хөгжим, бүжгийн салбарын сургалт зэрэг албан ба албан бус боловсролыг багтаасан. Иймд үүнийг өөр ямар нэг тусгай салбарт хуваарилах боломжгүй. Үүнийг салбар бүрт байдаг соёлын үйл ажиллагааг сурталчлахад тодорхой салбарын сургалт буюу бизнес эсхүл байгууллага гэж авч үзэж болно.

Хэрэглэхийг санал болгож буй ЭЗБТУАСА-ын 3220 (*Хөгжмийн зэмсгүүд*) ангилал нь хөгжмийн зэмсгийн үйлдвэрлэлийг багтаана. Соёлын мөчлөгийн чиг баримжааг ашиглахад хөгжмийн зэмсгийн үйлдвэрлэл нь уран сайхны илэрхийлэх үйлдвэрлэлийн нэг бүрэлдэхүүн (орц) болж буй учир хөгжмийн зэмсэг үйлдвэрлэлийг соёлын үйл ажиллагаа гэж үзнэ.

3.3 Олон улсын соёлын худалдаа: Уялдуулсан систем (УС) болон Төлбөрийн тэнцлийн үйлчилгээний ангиллыг (ТТҮА) ашиглах нь

Энэхүү бүлэгт соёлын бараа, үйлчилгээний олон улсын худалдааны асуудлыг авч үзсэн болно. Дэлхийн гаалийн байгууллагын боловсруулсан статистикийн дагуу Барааны ангилал, кодлолын (3-р хүснэгтийг харах) уялдаат системийн хувилбар 7-ийн дагуу соёлын бараа бүтээгдэхүүний урсгалын талаарх мэдээллийг цуглуулдаг бол харин төлбөрийн тэнцэл дэх өргөтгөсөн ангиллыг ашиглан соёлын үйлчилгээний талаарх мэдээ баримтыг цуглуулдаг байна. Эдгээр хоёр системийг ашиглан ямар ч эдийн засгийн системийн хүрээний зохих соёлын урсгалыг тодорхойлж болно.

Соёлын барааны олон улсын урсгал

Уялдуулсан системд бараа, бүтээгдэхүүнийг үндэсний утга агуулга, соёлын үнэ цэнэ, болон эдгээртэй адилтгах шалгуураар бус тэдгээрийн одоо байгаа бодит байдлаар нь ангилдаг. Энэ нь хилээр гарахад гаалийн мэдүүлэгт тэмдэглэсэн бодит барааг тусгадаг. Иймээс соёлын урсгалын бүрэн дүр зургийг гаргахын тулд бүтээгдэхүүний талаарх мэдээ баримтыг үйлчилгээний мэдээлэлтэй харьцуулах нь тун чухал юм. Олон улсын урсгалтай холбогдох ангиллын жагсаалтыг 5-р бүлгийн 3-р хүснэгтэд үзүүлэв. Олон улсын худалдааны стандарт ангиллын 4-р (ОУХСА 4) хянаж шинэчилсэн хувилбартай холбоотой Уялдуулсан системийн ангиллууд нь нарийвчлал багатай ч олон улс орны гаалийн статистикт өргөн хэрэглэгддэг.

Гэвч гаальд үндэслэсэн мэдээллийг хэрэглэн зарим соёлын салбаруудыг үнэлэхэд хүндрэлтэй байдаг. Жишээ нь: Барааны ангилал, кодлолын уялдуулсан системийг хэрэглэж үйлдвэрлэлийн болон гар урлалын үйлдвэрлэлийн ялгааг гаргах боломжгүй. Гар үйлдвэрлэлд дараах ангиллуудыг хэрэглэгддэг. Эдгээр нь:

5007	Торгон нэхмэл болон торгоны өөдөс
5111-5113	Ноосон нэхмэл болон малын үс, хялгас
5208-5212	Хөвөн даавуу
5309-5311	Цаасан сүлжмэл утасны нэхмэл материал
57	Хивс болон бусад шалны нэхмэл дэвсгэрүүд
60	Нэхмэл болон сүлжмэл даавуу

Гаалийн мэдүүлэгт өгсөн үнэлгээ зөвхөн хуулбартай хамаатай бөгөөд зохиогчийн эрхийн үнэлгээ ордоггүй тул киноны талаарх мэдээлэлд онцгой анхаарал тавих ёстой. Иймд эдгээр мэдээ баримтыг зохиогчийн эрхийн товчоонуудын цуглуулсан үйлчилгээний мэдээллээр гүйцээн нэмэгдүүлж оюуны өмчийн урсгалыг тодорхойлох ёстой.

Соёлын үйлчилгээний олон улсын урсгал

Соёлын үйлчилгээ болон худалдааны талаарх мэдээ баримтыг төлбөрийн тэнцлийн өргөтгөсөн ангиллын 6-р хянан шинэчилсэн хувилбар (IMF, 2008) болон БҮНА 2-т тодорхойлсон үйлчилгээний төрөлжүүлэлтийг үндэслэн нэгтгэх ёстой. Төлбөрийн тэнцэл дэх үйлчилгээний ангилал (ТТҮА) нь 2010 онд эцэслэн дуусах ёстой “Олон улсын үйлчилгээний худалдааны статистик эмхтгэл” (НҮБ, 2002)-ийн өөрчлөлтийн дагуу өөрчлөгдөх ёстой.

Нийлүүлэгч, хэрэглэгчид нь өөр өөрийн орондоо үлдээд зөвхөн үйлчилгээ нь хил давдаг учир үйлчилгээтэй холбоотой төлбөрийн тэнцэл нь гол төлөв гадаадад явагдах үйлчилгээтэй холбоотой.

Төлбөрийн тэнцэл дэх үйлчилгээний ангилал нь бусад олон улсын ангиллын адил соёлыг онцгой ангилалд хамруулдаггүй. Энд соёлын үйлчилгээг нэмэлт гэж ангилдаг бөгөөд хэм хэмжээний бус гэж үзээд мэдээ баримтыг системтэйгээр тогтмол цуглуулдаггүй. 2010 оны ангиллын өөрчлөлтийн үр дүнд соёлын үйлчилгээг илүү нарийн үнэлэх боломжтой болсон. **1-р хүснэгт**-ийг 2009 оны 6-р сард дахин хянаж шинэчилсэн ангиллуудад тулгуурлаж хийгдсэн.

Аялал жуулчлалын талаарх тоо баримтын ихэнх хэсэг нь соёлын үйлчилгээний адил зөвхөн гадаадын жуулчдад хамаатай Аялал жуулчлал гэсэн бүлэгт бүртгэгддэг. Аялал жуулчлалын кредит нь тухайн жуулчдын өөрийн хэрэглээнд олж авсан эсвэл тухайн оронд ирэх үедээ түр оршин суугчийн хувьд нь эдийн засгийн системээс гарч байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой. Аяллын дебит нь тухайн жуулчны хувийн хэрэгцээнд олж авсан эсвэл өөр нэг эдийн засгийн системээс өгч байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээгээр тодорхойлогдоно. Төлбөрийн тэнцлийн үйлчилгээний ангилалд аяллыг бизнесийн ба хувийн гэж салган ангилжээ. *Хувийн аялал* гэсэн ангилалд бүртгэгдсэн соёлын аялал жуулчлалын ихэнх хэсэг нь “ажил хэрэгтэй холбоотой бус, өөр зорилготой, тухайлбал, амралтаа өнгөрөөх, соёлын болон эрүүлжүүлэх арга хэмжээнд хамрагдах, найз нөхөд, хамаатан садантайгаа уулзах мөн түүнчлэн эргэл мөргөл үйлдэхтэй холбоотой бараа, үйлчилгээг” хамарна (IMF, 2008).

Хүснэгт 1. Төлбөрийн тэнцэл дэх үйлчилгээний ангиллаар тодорхойлогдсон соёлын үйлчилгээнүүд

ТТ 6	ТТҮА	Тэмдэг
Соёлын үндсэн үйлчилгээ		
1. A.b. 8	8.4.1.	Аудио-визуал бичлэгийн бүтээгдэхүүнийг хуулбарлах ба түгээн тараах тусгай зөвшөөрөл
	8.4.2.	Холбогдох бүтээгдэхүүнийг хуулбарлах ба дагалдах бүтээгдэхүүнийг түгээх тусгайзөвшөөрөл ¹
1.A.b.9.3.	9.3.1.	Мэдээний агентлагын үйлчилгээ ²
1.A.b.9.3.	9.3.2.	Бусад мэдээллийн үйлчилгээ ³
1.A.b.10.2.	10.2.2.	Зар сурталчилгаа, зах зээлийн судалгаа, олон нийтийн санал асуулга
1.A.b.10.3.	10.3.1.1.	Архитектурын үйлчилгээ
1.A.b.11.1.	11.1.1.	Аудио-визуал бүтээгдэхүүн
1.A.b.11.1.	11.1.2.	Холбогдох үйлчилгээ ⁴
1. A. b.11.2.	11.2.3.	Өв болон сэргээн засварлах үйлчилгээ ⁵
Тоног төхөөрөмж ба дагалдах материал		
1.A.b.8	8.3.	Компьютер програм хангамжийг хуулбарлах түгээх тусгай зөвшөөрөл
1.A.b.9.2.	9.2.1.	Компьютерийн үйлчилгээ
1. A.b.9.2.	9.2.2.	Компьютерийн бусад үйлчилгээ
Холбогдох соёлын үйлчилгээ⁶		
Аялал жуулчлал		
1.A.b.4.2.3.	4.2.3.	Аялал – Бусад хувийн ⁶

Тайлбар:

¹Энэ ангилалд жүжигчин, зохиолч, хөгжмийн зохиолч, уран барималчид болон бусад (үүнд тайзны засалч, хувцасны загвар зохион бүтээгч болон гэрэлтүүлэгч багтана) гэх зэрэг бусад урлаг, уран сайхны тусгай зөвшөөрлүүд багтана.

²Мэдээний агентлагийн үйлчилгээнд олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээ, гэрэл зураг, онцлог мэдээ мэдээлэл өгөх ажиллагаа багтана.

³Номын сан архивын үйлчилгээг багтаана.

⁴Соёлын бусад үйлчилгээг багтаана.

⁵11,2,3 ангилалд багтсан сэргээн засварлах үйлчилгээ, Өв болон сэргээн засварлах үйлчилгээ

⁶ Энэхүү ангилалд аяллын бүхий л хэлбэрийн (сургалт, ажил хэргийн болон эмчилгээний) хилийн чанадад гаргасан соёлын бүх зардлыг оруулна.

3.4 Соёлын салбар дахь ажил эрхлэлт: Ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал (АМОУСА)-ыг ашиглах нь

Уг бүлэгт соёлын бүтээгдэхүүнийг ганцаараа болон хэсэг бүлгээрээ, байгууллагаараа бүтээхэд оролцдог уран бүтээлч, үйлдвэрлэгч, түгээгчдэд хамаарах асуудлыг авч үзнэ. Тэднийг ажил хэрэг эрхлэлтээр нь АМОУСА-ыг ашиглан ангилалд оруулдаг.

Соёлын салбар дахь ажил мэргэжлийн дараах тодорхойлолтуудыг Австрали болон Шинэ Зеландын үйлдвэрлэлийн стандарт ангилал болон Канадын Соёлын статистикийн хүрээнд тулгуурлаж гаргасан. Хэдийгээр Австрали, Шинэ Зеландын соёлын статистик нь өргөн хүрээтэй ч энэхүү дэвшүүлж буй тодорхойлолт нь 2-р зурагт үзүүлсэн уран бүтээл, урлагтай холбоотой соёлын үндсэн салбаруудын ажил мэргэжлийн үзүүлэлтүүдэд төвлөрсөн.

Соёлын салбар дахь ажил мэргэжилд бүтээлч, уран бүтээлч үйлдвэрлэл болон соёлын өв цуглуулж, хадгалахтай холбоотой ажил мэргэжлүүд багтсан. Эдгээр ажил мэргэжлүүд нь дараах зорилт үүргүүдэд чиглэсэн байдаг. Үүнд:

- Соёлын, бэлгэ тэмдгийн болон оюун санааны утга учрыг бүтээх, хөгжүүлэх, хадгалах, тусгах;
- Гол төлөв оюуны өмчийн эрхээр баталгааждаг соёлын бараа, үйлчилгээ зэргийг бүтээх, үйлдвэрлэх, түгээх;
- Уран бүтээлч зорилгыг хангах (визуал, хөгжим, уран зохиол, бүжгийн урлаг, жүжгийн урлагийн г.м) багтаж байна.


2-р зурагт тодорхойлсны дагуу холбогдох салбарыг багтаах бөгөөд илүү өргөн хүрээний тодорхойлолт нь спорт болон идэвхтэй амралт зэрэг чөлөөт цагаараа хийдэг үйл ажиллагаануудад хамаардаг. Эдгээр салбаруудад спорт, идэвхтэй амралт, чийрэгжүүлэлт, амралт, таашаал авах, хүч чадлаа сэлбэх зэрэгтэй холбоотой үйл ажиллагаанууд багтана.

Соёлын ажил эрхлэлтийг хэмжих нь

Соёлын ажил эрхлэлтийг тодорхойлохын тулд дизайн зэрэг соёлтой холбоотой болон холбоогүй соёлын ажил мэргэжилтэй хамааралтай мэргэжлийг оруулах шаардлагатай (3-р зургийг үз).

3-р зурагт соёлын салбарыг тусгахдаа албан ба албан бус соёлын төрөл бүрийн бүлгүүдийг (саарлаар тэмдэглэсэн хэсэг) системд нь харуулсан. Соёлтой хамааралгүй салбарыг ажил эрхлэлтийн зурагт оруулах бол зөвхөн тэдгээрт соёлын ажилтнууд ажилладаг бол л хамруулна. Жишээ нь: автомашин үйлдвэрлэлийн салбарын дизайнер нь соёлын бус салбарт ажилладаг соёлын ажилтан юм.

Зураг 3. Соёлын ажил эрхлэлт



Соёлын салбарын ажил эрхлэлтэд тосгоны² гар урлал ихээхэн хувь нэмэр оруулдаг. Хөгжиж буй орнуудад хөдөө аж ахуй, газар тариалангийн болон бусад ажиллагсад гар урлалын нэмэлт мэргэжилтэй байж болох учир соёлын ажил мэргэжлийг нэмэлт гэж үзэх нь элбэг байдаг. Харин энэ мэдээ баримт хүн амын болон ажиллах хүчний судалгаанд хамрагдахгүй байх нь элбэг бөгөөд ийм төрлийн нуугдмал буюу “шигтгэсэн” соёлын мэргэжлүүд нь түүвэр судалгааны асуулгаар нарийн тодорхой хэмжигддэггүй. Эдгээр нь ихэнх тохиолдолд аж ахуй эрхлэлтийн асуулгад хамрагддаггүй өөрөө өөртөө ажил олгогч буюу албан бус 10-с доош ажилчинтай жижиг компаниуд байдаг. Ерөнхийдөө бол жижгэвтэр байгууллага дээр соёл уран бүтээлийн шинж чанартай ажлын хувь өндөр гэж үздэг бөгөөд энэ тал дээр Европын статистик ч соёлын салбарын ажил эрхлэлтийг дутуу үнэлэх нь байдаг.

Үүнээс гадна соёлын салбарын ажил эрхлэлтэд сайн дурынхан болоод цалингүй ажиллагсад их үүрэг гүйцэтгэдэг. Энэ төрлийн ажил эрхлэлтийг илүү бүрэн дүүрэн үнэлэхийн тулд шинэ нэмэлт арга зүйн судалгаа шаардлагатай.

Соёлын бус үйл ажиллагаанд соёлын ажил мэргэжлийг тодорхойлохын тулд (Зураг 3-ийг үз) ажил мэргэжлийн олон улсын стандарт ангиллын тоо баримтыг үйлдвэрлэлийн ангиллын ангилалтай зөв хослуулан хэрэглэх нь чухал (Каннигам ба Хиггс, 2008).

АМОУСА 08-ын дагуу соёлын ажил мэргэжлийг тодорхойлох нь

АМОУСА нь ажил, туршлага гэсэн хоёр ойлголтод тулгуурласан. АМОУСА 08 ангилалд ажил гэдгийг “өөрөө өөртөө ажил олгох ажиллагааг оруулаад тодорхой ажил олгогчийн төлөө багц ажил гүйцэтгэж, үүрэг даалгавруудыг биелүүлэх чадвар юм” гэжээ. Туршлага гэдэг нь “тодорхой ажилтай холбоотой үүрэг, даалгавруудыг биелүүлэх чадвар” юм (ILO, 2008).

Янз бүрийн арга туршлагыг шаарддаг маш олон төрлийн мэргэжлийг хамардаг тул мэргэжлийн бүх төрлүүдийг тусгай ангилалд оруулах боломжгүй ч ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэн, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас ОУХБ-д 2007 онд санал болгосноор хамтын саналд үндэслэсэн соёлын ажил мэргэжлийг илүү сайн тодорхойлох ажил мэргэжлийн шинэ ангиллуудыг АМОУСА 08-д оруулсан байна.

АМОУСА 08 болон *ЮНЕСКО-гийн 2009 оны ССХ-д* соёлын салбарын дараах үндсэн ажил мэргэжлүүдийн ангиллыг ашигласан. Үүнд:

- 262 Номын санч, архивч, хадгалалтын ажилтнууд;
- 264 Зохиолч, сэтгүүлч, хэл шинжээчид (шинэ ангилал);
- 265 Бүтээлч, жүжигчид;
- 343 Урлаг, соёл, хоол хүнсний холбогдох мэргэжилтнүүд;
- 3521 Нэвтрүүлэг, дүрс, дуу бичлэгийн салбарын мэргэжилтнүүд;
- 73 Хэвлэл болон гар урлалын мастерууд (шавар, металл, шил, мод, даавуун гар урлалтай холбоотой бүх урчуудыг багтаасан шинэ ангилал).

² Тосгоны гар урлал гэдэг нь бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрт бус гэртээ гар аргаар үйлдвэрлэхийг хэлнэ.

5-р бүлгийн 4-р хүснэгтэд соёлын салбарын мэргэжлийг тодорхойлох үндэс болохуйц ангиллуудын жагсаалтыг үзүүлэв. Гэсэн хэдий ч соёлын салбарын ажил эрхлэлтийг үнэлэхэд шийдвэрлээгүй асуудлууд байсаар байна. Ажил мэргэжлийн стандарт ангилалд ажил мэргэжлүүд ангилагдсан ч тэдний хоорондын зааг ялгааг нарийн гаргахаар хийгдээгүй юм. Түүнчлэн АМОУСА-аас тусдаа шинэ ангилал үүсгэхүйц олон тооны ажиллагсадтай мэргэжлүүд бий. Жишээ нь: дараах үндсэн ангиллуудад соёлын мэргэжлийг ялгаж салгахад бэрх байна. Эдгээрт:

Соёлын өв болон хадгалалт

Соёлын өв болон тэдгээрийн хадгалалттай холбоотой археологич, хадгалалтын ажилтнуудын мэргэжлийн тодорхойлолт эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилалд багтаагүй ч 2632 гэсэн ангилалд багтсан (социологич, антропологич болон холбогдох мэргэжилтнүүд). Энэхүү салбарт ажиллагсад голцуу шинжлэх ухааны мэдлэг, ажлын арвин их туршлагатай хүмүүс байдаг тул АМОУСА-ын мэргэжилтнүүд 2 хэмээх үндсэн бүлэгт хамааруулж болно.

Менежер, ахлах мэргэжилтэн, хууль тогтоогчид

Менежер, ахлах мэргэжилтэн, хууль тогтоогчдын хувьд бол тэдний мэргэжил зөвхөн АМОУСА-ын 1113-тай л (уламжлалт суурингийн ахлагч, омгийн толгойлогчид) холбоотой. Гэсэн хэдий ч урлагийн компанийн захирал зэрэг мэргэжлийг хаана хамааруулах асуудлыг эргэж харах нь зүйтэй. Тухайлбал урлагийн хүрээний менежер, албан тушаалтнуудыг харьяалах ангилал дутагдаж байгаа юм.

Боловсрол

Соёлын салбарт багш нарыг "Бусад багш нар" гэсэн төрөлд хамааруулдаг бөгөөд үүнд 2354 (бусад хөгжмийн багш нар), 2355 (бусад урлагийн багш нар), 2352 (бусад хэлний багш нар)³ багтдаг ч ерөнхийдөө бол бүх шатны боловсролын (дээд, тусгай мэргэжлийн болон дунд) урлагийн болон хүмүүнлэгийн ухааны багш нар энэ ангиллуудад ороогүй бөгөөд тэднийг албан ба албан бус мэргэжлийн боловсролын ангилалд хамруулж болох юм.

Мэдээлэл, харилцааны технологи (МХТ)

Мэдээлэл, харилцаа холбооны технологитой холбоотой соёлын ажил мэргэжлүүд ихэвчлэн аудио-видео ажил мэргэжил, мультимедиа дизайнер гэх зэрэг шинэ хэрэгслүүдтэй голцуу холбогддог. Тэдгээр нь *Аудио болон интерактив хэрэгсэл* болон *Дизайн, бүтээлч үйлчилгээ* гэсэн хоёр үндсэн салбарт хуваагдана. Гэсэн ч компьютер графикийн мэргэжилтнүүдийг оролцуулаад нэвтрүүлэг, мультимедиа үйл ажиллагааны менежерүүдийг багтаасан тусгай ангилал АМОУСА 08-д байхгүй.

³ Австрали гэх мэт зарим орнуудын хувьд хэлний багш нарыг соёлын ажил мэргэжилд хамруулдаггүй.

3.5 Соёлын өвийг хэмжих нь

Өмнө дурьдсанчлан соёлын өвийн салбар нь бусад салбараас огт өөр загвараар тодорхойлогддог. Энэхүү салбарын үйл ажиллагааны дийлэнх нь соёлын өвийн хадгалалт, хамгаалалттай холбоотой учир эдийн засгийн үүднээс авч үзвэл соёлын өв нь хөрөнгө юм. Хөрөнгийн үнэ цэнэ нь тэдгээрийг хэрхэн тордон хадгалж байгаагаас шалтгаалан буурах буюу өсч болно. Олон нийт тэдгээрийг хэрхэн үнэлж дүгнэж, эрхэмлэн дээдэлж байгаад үндэслэж соёлын өвийн эдийн засгийн үнэ цэнэд эдийн засгийн дүн шинжилгээ хийсэн (Наврид ба Рэди, 2002). Энэ тооцоонд ирээдүй үедээ зориулан хэн нэг хүн соёлын өвийг хадгалах болон түүхэн дурсгалт газарт очиход зориулж хэдий хэмжээний төлбөр төлөхөд бэлэн байгааг асуун соёлын өвийн үнэ цэнийг тогтоожээ. Гэхдээ энэхүү бодит бус өртөг болон аяллын зардлын улмаас орон нутгийн үнэт зүйлст зориулах хөрөнгийг эргэн нөхөх асуудал хүндрэлтэй болохыг онцгойлон тэмдэглэх ёстой.

Эдийн засгийн үнэт зүйл байхын сацуу соёлын өв нь нийгмийн баялаг юм. Энэ нь гоо зүй, түүх, нийгэм, оюун санаа болон боловсролын үнэ цэнийг бүрдүүлдэг. Биет соёлын өвийн газар нутгийг ихэвчлэн биет бус соёлын өвийн элементүүдийг агуулдаг баяр ёслолыг тэмдэглэхэд ашигладаг. Хөгжингүй орнуудад хөшөө дурсгал, музей гэх зэрэг соёлын үнэ цэнэтэй өмчтэй харилцахдаа бүртгэлд оруулдаг. Гэвч ердийн аялал жуулчлалын статистик үзүүлэлтээс соёлын аялал жуулчлалын мэдээ баримтыг ялгаж салгахад цаашдын нэмэлт боловсруулалт хийх шаардлагатай. Жуулчид болон соёлын өвийн бүсийн орон нутгийн оршин суугчдын дунд түүвэр судалгаа хийх нь статистик үзүүлэлтийн чухал хэрэгсэл юм. Хөгжиж буй орнуудад соёлын өвийн бүсэд очиж үзэх хүмүүсийн судалгаа нь хэдийгээр үзэгчдээс тоглогчдыг ялгахад хүндрэлтэй байх зэрэг асуудлууд байж болох ч уг судалгаа нь хэмнэлттэй байж, соёлын статистикийн хүрээнд том хэмжээний үүрэг гүйцэтгэдэг.

Зохиогчийн эрхийн гүйцэтгэх үүрэг

Зохиогчийн эрх нь зохиол бүтээлийн илрэх хэлбэрээс үл шалтгаалан уран зохиол, шинжлэх ухаан, уран сайхны салбарын бүхий л төрөлд хэрэглэгдэнэ (Олон Улсын Оюуны Өмчийн Байгууллага, 1979). Уран зохиол, уран сайхны бүтээл нь ном болон бусад туурвилууд, хөгжим, жүжгийн зохиол, бүжгийн зохиол, фото зураг, кино, уран барилгын зураг төсөл, хөөмөл, цутгамал, уран зураг болон уран баримал зэргийг багтаана (Олон Улсын Оюуны Өмчийн Байгууллага, 1979). ЮНЕСКО зохиогчийн эрх, үүнтэй төстэй хууль эрхийн хамгаалалтыг “хувь хүний уран бүтээлч санааг нэмэгдүүлэх, соёлын салбарыг хөгжүүлэх, соёлын олон төрөл зүйлийг дэмжих” үндсэн нөхцөл гэж үзсэн байна (ЮНЕСКО, 2009а).

Оюуны өмчийн эрхийг тодорхойлдог бараа, үйлчилгээг тодорхойлох нь соёлын эдийн засагт оруулах хувь нэмрийн гол бүрэлдэхүүн хэсэг болдог бөгөөд хууль эрх зүйн тодорхой системтэй холбоотойгоороо давуу талтай. ССХ-д соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зохиогчийн эрхийн дагуу байх боломжтой гэж тодорхойлогддог. Зохиогчийн эрх нь салбар бүрийн ихэнх элементүүдэд ашиглагддаг.

Олон улсын оюуны өмчийн байгууллагаас оюуны өмчийн салбарын эдийн засагт оруулах хувь нэмрийг (Олон Улсын Оюуны Өмчийн Байгууллага, 2003) тодорхойлох зарчмуудыг боловсруулсан юм. “Зохиогчийн эрхийн үндсэн салбаруудын” тодорхойлолт нь ССХ-н дэх соёлын салбаруудтай адил төстэй боловч зарим нэг нэмэлт тайлбаруудтай. Олон улсын оюуны өмчийн байгууллагын зохиогчийн эрхийн үндсэн салбаруудад програм хангамж болон техник хангамжийн зохиогчийн эрх багтдаг бол ССХ-д багтдаггүй. Түүнчлэн олон улсын оюуны өмчийн байгууллагаас гаргасан соёлын салбарын тодорхойлолт нь уг ССХ-д тодорхойлсноос өөр байгаа. Учир нь уг ССХ соёлын амьдрал дахь практик болон музейн үйл ажиллагаа зэрэг оюуны өмчийн эрхийн салбарыг хамардаггүй.

4. Соёлын статистик: Нийгмийн үзүүлэлтүүдийг хэмжих нь

4.1. Соёлын оролцоог хэмжих нь

Өмнөх бүлэгт статистик мэдээллийг олон улсын ангиллуудын (эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал, Уялдуулсан систем) хэрэглээний талаар авч үзсэн билээ. Харин энэхүү бүлэг нь Соёлын статистикийн хүрээ болон соёлын үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох нийгмийн үзүүлэлтүүдийн хэмжилтийн асуудлыг авч үзнэ.

Эдийн засгийн үйл ажиллагаагүй албан бус салбаруудад байнга үзэгддэг соёлын нийгмийн үзүүлэлтүүдийг хэрхэн үнэлэх тухай асуудалд гол хүндрэл гарч ирж байгаа юм. Соёлын нийгмийн хэмжүүрийн зарим асуудал нь соёлын бэлгэдлийн чанартай үнэт зүйлс буюу эдгээрийн гүйцэтгэдэг үнэт зүйлс болон ижилслээ мэдэрснээр нийгмээс салан тусгаарлах бус харин нийгэм хамт олонтой нэгдэн, тогтвортой байх үүрэгтэй нь холбоотой байдаг. Эдгээр үүргүүд нь соёлын бодит бус хэмжилтээр илэрдэг бөгөөд, амьдрал дээр олон нийт, бүлгийн хүрээнд голлон хэрэгждэг тул эдийн засгийн харилцаанд ордоггүй аспектиудыг хамардаг. Ер нь соёлын нийгмийн асуудлыг хэмжихэд ямагт амаргүй байдаг. Гэсэн хэдий ч соёлын нийгмийн үзүүлэлтүүдийг судлахад ашиглаж болох нийтээр хүлээн зөвшөөрсөн цөөн хэдэн статистикийн тодорхой стандартууд байдаг.

Соёлын оролцооны талаарх мэдээллийн үндсэн эх сурвалж нь өрх болон зарцуулсан цаг хугацааны талаарх асуулга юм. Гэхдээ энэ нь ихээхэн зардал шаарддаг төдийгүй улс орнууд боловсруулсан асуулгадаа соёлтой холбоотой асуудлыг маш бага оруулдаг. Харьцуулалтыг олон улсын хүрээнд үүсгэн соёлын нийгмийн аспектиудаар нэгдмэл үзүүлэлтүүдийг бий болгохыг тодорхойлолт болон стандартын хэрэгслийн цаашдын хөгжил шаардаж байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор энэхүү хамрах хүрээнд соёлын нийгмийн загварыг нийтээр ойлгон ухамсарлах асуудлаар өргөн зөвшилцөлд хүрч, улмаар соёлын нийгмийн хэмжилтүүдийг тодорхойлох, үзүүлэлт тодорхойлолтуудыг бий болгосноор статистикийг хөгжүүлэх ерөнхий чиглэл өгөхийг эрмэлзлээ.

Соёлын оролцоо

Соёлын статистикийн хүрээ нь соёлын үйл ажиллагаанд оролцох бүхий л элементүүдийг (мөнгө санхүүгийн байдал, өрх гэрт өрнөх соёлын үйл ажиллагаа зэргээс бусад) албан ёсны ажил эрхлэлт, үзэж оролцох (театрт тоглолт үзэх буюу төлбөр хураамж төлөх гэх зэргээр) эсвэл албан бус үйл явц (олон нийтийн үйл ажиллагаа, гэр бүлийн үйл ажиллагаа)-д оролцох зэргийг хамарсан юм.

Соёлын үйл ажиллагаан дахь оролцооны эдийн засгийн хэмжилтийг хэрэглэгчдийн соёлын салбарын бараа, үйлчилгээ болон төлбөрт арга хэмжээнд зарцуулсан мөнгөний статистикийн үзүүлэлтээр хийж болно. Эдгээр үзүүлэлтийг өрхийн зардал болон үйл ажиллагааны судалгаагаар хэмжиж болох бөгөөд удирдлагын мэдээ мэдээллийг мөн ашиглаж болно.

“Хэрэглээ” гэсэн нэр томъёо нь хэрэглэгчийн авсан төлбөртэй үйлчилгээг илэрхийлдэг бол “оролцох” гэдгийг сонирхогчийн, төлбөргүй үйл ажиллагаанд оролцох гэсэн утгаар голлон хэрэглэж ирсэн. Гэтэл амьдрал дээр хэрэглэгч, оролцогчид нь албан бус үйл ажиллагаанд ямар нэг байдлаар төлбөр төлдөг тул эдгээрийг хооронд нарийн ялгаж салгахад хүндрэлтэй. Жишээ нь: “Хэрэглэгч” жүжигчний байр, хоол ундыг бэлтгэн хариуд нь тоглолтыг нь үзсэнээр харилцан бие биедээ үйлчилсэн болно. Үүнтэй нэг адилаар сонирхогч, мэргэжлийн бус жүжигчид сургалт, бэлтгэлд хамрагдсанаар “мэргэжлийн болох” боломжтой. Ингэснээр нийгмийн буюу сонирхогчдын соёлын үйл ажиллагаа нь соёлын олон салбарын эх сурвалж болж болох талтай.

Соёлын оролцооны талаарх бие даасан асуулгыг Европын холбооны орнуудад голлон явуулж байсан. Европын холбооны соёлын статистикийн LEG туршилтын хэсгийн удирдлага (LEG Eurostat, 2000) “Евробарометр” судалгааны цувралд хэрэглэж байсан бүс нутгийн загварыг боловсруулах оролдлого хийсэн. Тэр үеэс хойш энэхүү загварт нийцүүлж хэрэглэн Европчуудын соёлын үйл ажиллагааны оролцооны талаар уялдаат мэдээлэл цуглуулахын тулд гурван удаа асуулга явуулсан. Беннеттийн судалгаагаар Европчууд урлаг болон чөлөөт цаг, зугаа цэнгэлийг өдөр тутмын амьдралаараа соёлын салбарт оруулдаг гэж тодорхойлсон. Уг тодорхойлолт нь “анги, хүйс зэрэг нийгмийн ач холбогдол бүхий ард иргэд, бүлгүүдийн хувьд зөвхөн урлаг, уран сайхны илэрхийллээр бус өдөр тутмын амьдралынх нь хэв маягт агуулагдан байдаг тэдний соёлын үнэт зүйлс, сонирхол, зан үйл, язгуур (үндэс угсааны) ялгаа, ижилсэл нь хамааралтай” юм (Беннетт, 2001).

Ийнхүү соёлын оролцоонд амьдрал, уламжлал, сүсэг бишрэлийг тусгадаг, хэрэглээг агуулсан нийгэм дэх үйл ажиллагаа болох соёлын дадлууд багтана. Эдгээр нь албан ёсны төлбөрт арга хэмжээ болох кино, концерт үзэх, албан бус олон нийтийн цуглаан, сонирхогчдын уулзалт, түүнчлэн өдөр тутмын үйл явдал, тухайлбал ном унших зэргийг багтаана. Соёлын амьдралын оролцоо нь ерөнхийдөө олон нийт, нийгмийн бүлэг, яс үндэс, нас, хүйс зэргийг бүхэлд нь хамруулан хэмжинэ. Яс үндэс, нийгмийн бүлэг, хүйс зэрэгт тулгуурласан дүн шинжилгээ нь мөн соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийн хэмжилттэй холбоотой байж болно.

Түүнчлэн соёлын оролцоо нь идэвхтэй, идэвхгүй зан байдлын аль алиныг хамарна. Энэ нь концерт үзэгч болон хөгжим сонирхдог хүмүүст хамаарна. Соёлын оролцооны асуулгын зорилго бол идэвхтэй, идэвхгүй зан байдлыг хооронд нь ялгаж салгах бэрхшээлтэй байдлыг үл харгалзан бүх үе шатанд нь үнэлгээ өгөх юм. Жишээ нь: Зарим фестивал дээр хувь хүн нэг талаараа оролцогч (идэвхтэй, бүтээлч, бусдыг урамшуулан дууддаг) байхад, нөгөө талаараа зөвхөн үзэгч (идэвхгүй, зөвхөн урам зориг авах) байдаг. Соёлын оролцоо нь мэргэжилтэй холбоотой тул ажил эрхлэлттэй холбоотой хийгдэх үйл ажиллагаатай холбоогүй (ILO, 1988). Жишээ нь: Соёлын оролцоонд музей үзэгч багтах ч төлбөрт хөтөч тайлбарлагч багтахгүй.

ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэн 2006 онд Европын холбооны “Евробарометр” загварыг хөгжиж буй орнуудын соёлын үйл ажиллагааны нөхцөл байдалд хэрэглэх тухай илтгэлийг бэлтгэсэн юм. Энэхүү илтгэлд соёлын үйл ажиллагааг дараах гурван ангиллаар тодорхойлжээ (ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэн, 2006b). Үүнд:

- i) **Өрхөд суурилсан** (culture d'appartement): телевизор үзэх, радио сонсох, хөгжмийн нэвтрүүлэг үзэх ба хөгжим сонсох, ном унших, мөн компьютер болон интернэт ашиглах зэрэгт зарцуулах цаг хугацаатай холбоотой.
- ii) **Өрхөөс гадуур** (culture de sortie): кинотеатр, театр, концерт, музей, хөшөө дурсгал болон соёлын өвтэй газрууд зэрэг соёлын дурсгалт газруудад очихтой холбоотой.
- iii) **Соёлыг таних** (culture identitaire): соёл сонирхогч, соёлын холбооны гишүүнчлэл, түгээмэл соёл, угсаатны соёл, ард түмний дадал болон залуучуудын соёл зэрэг багтана.

Өрхөд суурилсан соёлын үйл ажиллагааг хэмжих нь

Өрхөд суурилсан соёлын үйл ажиллагаануудыг хэмждэг ердийн арга хэрэгсэл нь цаг ашиглалтын судалгаа юм. Өрхөөс гадуур болон соёлыг таних хэсгүүдийг хэмжиж тогтооход түүвэр судалгаа тохиромжтой байдаг.

НҮБ-ын үндэсний статистикийн хэлтэс “Төлбөрт болон төлбөрт бус ажлын хэмжилтийг сайжруулах” арга хэмжээний хүрээнд НҮБ-ын “Цаг ашиглалтын судалгааны үйл ажиллагааны олон улсын ангилал” хөтөлбөрийг боловсруулсан байна (ЦАСҮАОУА), (НҮБ 2005). Энэхүү ангилал нь зарцуулсан цаг хугацааны статистик тооцоог хөгжиж буй болон хөгжингүй орнуудад аль алинд нь ашиглуулах зориулалттай. Түүнчлэн энэ нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн үйлдвэрлэл бүтээмжийн үйл ажиллагааны тоо хэмжээг сайжруулах зорилготой. ЦАСҮАОУА нь олон нийтийн дадлыг багтаасан соёлын дадал заншлын иж бүрэн жагсаалттай цорын ганц ангилал юм. Ангиллын жагсаалтыг 5-р бүлгийн 5-р хүснэгтэд харуулав.

Өрхөд суурилсан дадал заншлыг “байршил”, “аяллын хэлбэр”, “хэнд”, “хэнтэй” гэсэн харилцан адилгүй нөхцөл байдлаар тодорхойлж ангиллаа.

ЦАСҮАОУА-ын бүтцээр Үндэсний тооцооны системийн ангиллын үйл ажиллагаанд оролцогч хувь хүмүүсийг хоёр том бүлэгт хуваасан байна. Энэ хоёр бүлэг нь мэргэжлийн бүтцээрээ хоорондоо холбоотой бөгөөд өрхийн гишүүд нь хувийн аж ахуй эрхэлдэг бөгөөд бүтээгдэхүүн нь аж ахуйдаа нэмэр хандив болдог, харин нөгөө хэсгийн бүтээгдэхүүн нь хувийн аж ахуйгаас бусад бүтцийн салбар хэсэгт хамаардаг байна (UNSD, 1998).

Соёлын оролцоог дахин дахин судлан шинжлэхэд маш их нөөц бололцоо шаардагддаг. Энэхүү хамрах хүрээнд оролцооны асуулга судалгааг ерөнхий түвшинд хийсэн ба тухайн соёлын үйл ажиллагааг хамаардаг салбарыг бүртгэхэд голлож төвлөрсөн. Энэ төрлийн судалгааг хөгжим, бүжиг, уншлага зэрэг салбарт хийхэд нийгмийн асуудлыг нь харах, түүнчлэн сонирхогчдын болон уран сайханчдын бүтээлийг мэргэжлийн бүтээлтэй холбох зэрэг боломжийг олгодог. Ийм холбоо нь соёлын салбарын үндсэн асуудал болох арилжаа, түүний нийтэд бүхэлд нь үзүүлэх нөлөөг судлахад амин чухал ач холбогдолтой юм.

4.2 Биет бус соёлын өвийг хэмжих нь

Энэ бүлэгт биет бус соёлын өвийг хэмжих эхний элемент, арга зүйг авч үзнэ. Бие даасан бүлгүүдийн хэрэгцээг ханган тэднийг цаашид хөгжүүлэхийн зөв бодлого тодорхойлохын тулд энд тусгай хэмжих хэрэгсэл шаардлагатай.

Статистикийн энэхүү хамрах хүрээнд биет бус соёлын өвийг “олон нийт болон зарим тохиолдолд тодорхой хүмүүс хүлээн зөвшөөрч буй дадал заншил, төлөөлөл, илэрхийлэл, мэдлэг, чадвар түүнчлэн тэдэнтэй холбоотой арга хэрэгсэл, биет, түүхэн дурсгалт зүйлс болон соёлын орон зай” гэж авч үзжээ (ЮНЕСКО, 2003b, Зураг 2). Иймээс биет бус соёлын өв нь соёлын аль ч салбарт үзэгдэж болох бөгөөд энэ чанараараа тус хамрах хүрээний холбогдох салбар байдлаар хаана ч гарч ирж болох юм.

Биет бус тул зарим ББСӨ-ийн бүтээгдэхүүнийг тоо болон чанарын хувьд хэмжихэд нэн бэрх байдаг тул ББСӨ-ийн бүх илрэлийг хэмжих шаардлагагүй юм.

Хүрээ 1. Европын цаг ашиглалтын судалгааны асуулгын удирдамж⁴

Арга зүйн үндсэн удирдамж болгон дараах зүйлсийг авсан байна. Үүнд:

- Асуулга нь хүн амын тодорхой нэг хэсэг бус нийт хүн амыг хамрах ёстой. Хамгийн багадаа 10 болон түүнээс дээш насныхныг хамруулбал зохино. Хэрэв ингэх боломжгүй бол 15 болон түүнээс дээш насныхныг хамруулах шаардлагатай.
- Түүврийн хэмжээ нь бүх үнэлгээний төлөөллийн үр дүн болон нас, хүйс, боловсролын түвшин зэрэг хүн ам зүйн үзүүлэлтүүдийг бүрэн хангавал зохино.
- Санал асуулга 2 өдөр явагдал зохионо: Нэг нь 7 хоногийн дундуур, нөгөө нь 7 хоногийн сүүлээр.
- Цаг ашиглалтын судалгаа (ЦАС) дараалан 12 сарын турш хийгдэнэ. Хэрэв ингэх боломжгүй бол ердийн 7 хоногийн өдрүүдийг оруулж болно.
- 10-15 минутын зайтайгаар тэмдэглэл хөтөлнө.
- Асуулгад үндсэн ба туслах ажлыг оруулна. Машин жолоодонгоо хөгжим сонсох, аяга тавга угаангаа телевизор үзэх гэх зэрэг мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой дадал зуршлыг хамруулах нь тун чухал юм.
- Асуулгад оролцогчдод ялангуяа олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахтай холбоотой өргөн хэмжээний үйл ажиллагааны ангиллын жагсаалт ашиглуулбал зохино.

ЦАСҮАОУА нь нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой дадал зуршлыг хэмжих хамгийн оновчтой арга боловч судалгаа хийхэд маш өртөг өндөртэй байдаг. Харин үүний оронд түүвэр судалгааны асуулгад хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглаж хэр их цаг хугацаа зарцуулж буй талаар асуулт оруулж, 7 хоногийн ажлын болон амралтын өдрүүдэд хүмүүсээс судалгаа авах боломжтой. Энэ тохиолдолд урьдчилан ангилсан үйл ажиллагааны жагсаалтыг хэрэглэнэ.

Дээрх 2 ангилал нь түгээмэл бус, ховор тохиолдох дадал заншилтай холбоотой тул *өрхөөс гадуурх* болон *соёлыг таних* зорилгоор энэ хэлбэрийн асуулгыг хийхэд тохиромжтой. Түүнчлэн олон улсын хэмжээний харьцуулалт хийх боломжтой байлгахын тулд улс үндэстний түвшинд хийх санал асуулга нь доорх арга зүйн шалгууруудыг хангаж байх ёстой. Эдгээрт:

- Ердийн үргэлжлэх хугацаа нь 1 жил байна. Асуулгад оролцогчид сүүлийн 12 сарын хугацаанд оролцсон соёлын үйл ажиллагааныхаа талаар мэдэвлэнэ.
- Түүвэрлэлтийн хамгийн жижиг нэгж нь хувь хүн байна. Ганцаарчилсан ярилцлага хийхээс (өрхийн судалгаанд ихэвчлэн хэрэглэгддэг) зайлсхийх ёстой. Учир нь судалгаанд оролцогчид өрхийн бусад гишүүдийнхээ соёлын бүх үйл ажиллагааны талаар мэддэггүй.
- Боломжтой бол судалгааны хамрах хүрээ нь нийгмийн ерөнхий судалгаа, амралт чөлөөт цагийн судалгаа гэх зэрэг соёлын оролцооноос ч илүү өргөн хүрээтэй байж болно. Улмаар олон улсын түвшинд харьцуулалт хийж ашиглаж болно. Соёлын оролцоог хэтрүүлж үнэлдэг соёлын хандлагад эдгээр санал асуулгыг зориулдаг ч хэрэв өөр тоо баримт байхгүй бол зорилтот асуулгыг ашиглаж болно.

Цаг ашиглалтын судалгааны асуулгын удирдамжийг хөгжиж буй орнуудад тохируулан хэрэглэх нь:

- Нийгэм-хүн ам зүйн шинж байдал: Хөгжиж буй орнуудад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах дадал зуршлын талаар тоо баримт цуглуулахад өргөн ашигладаг 5 болон түүнээс дээш насныхныг хамруулбал зохино. Нас, хүйс, боловсролын түвшин, үндсэн үйл ажиллагаа, орлогын түвшин, угсаатны бүлэг гэх зэрэг хүн ам зүйн хувьсах хүчин зүйлсийг харгалзан үзнэ.
- Түүврийн хэмжээ: Холбогдох шинж байдлынхаа төлөөлөл нь болж чадах хүн амын тоо, шинж байдлыг харгалзан түүврийн хэмжээг төлөвлөнө.
- Нэр төрөл, ангилал: Олон улсын хэмжээнд харьцуулалт хийх боломжтой болгохын тулд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улсын ангиллыг ашиглах хэрэгтэй.
- Ажлын баг: Соёлын салбарын төрөл бүрийн нэгжүүдэд хамааралтай хүмүүсийн дунд уг ажлыг зохион байгуулна. Сэдвийн асуулгыг найдвартай сайн боловсруулахын тулд статистикч, эдийн засагч, соёл арга зүйч нарыг багтаасан салбар хоорондын холимог ажлын багийг бүрдүүлэх нь зүйтэй.

⁴Eurostat Европын Холбооны статистикийн албанаас *Европын уялдуулсан цаг ашиглалтын судалгаан (HETUS)* дээр олон тооны удирдамжууд хэвлүүлж гаргасан. Эдгээрийг дараах вэб хуудаснаас үзэж болно: http://epp.eurostat.ec.europa.eu/cache/ITY_OFFPUB/KS-CC-04-007/EN/KS-CC-04-007-EN.PDF

ББСӨ нь дуу хөгжим, өгүүлэл, бүжиг болон бусад урлагийн тоглолтын төрлөөр илэрч байвал өөр арга хэмжээ авах шаардлагатай. Жишээ нь: асуулгыг зохих түвшинд (орон нутаг бүс нутаг, үндэсний түвшинд) явуулж чадвал оролцогч/гүйцэтгэгчдийн⁵ тоог тусгаж чадна. Судалгаанд агуулга, дамжуулах арга хэлбэрийг баримтжуулж болно.

Биет бус соёлын өвийн биет бус байдал нь хэмжихэд түвэгтэй болгодог учир түүнийг хэмжих хэрэгсэлд арга зүйн цаашдын боловсруулалт зайлшгүй чухал.

Хэл

Аливаа улс орнуудын хувьд хэл нь чухал хувьсах хэмжигдэхүүн байдаг. Хэл нь биет бус соёлын өвийн илэрхийлэл, дамжуулагч, хүрээлэн буй орчныг болон тухайн бүлэг хүмүүсийн нийгэм болон оршин буй орчны хүртэх ойлгох арга хэрэгсэл нь байдаг.

Хүмүүсийн ярьж буй хэл, тухайн хэл дээр ярьж буй хүний тоог хэмжих асуудлын талаар маргаан их байдаг. Хэл шинжээчид дараах хоёр үзүүлэлтийг ашиглан хэлийг тодорхойлдог. Үүнд: 1) Хэл нь харилцан ойлгодог ярианы хэрэгслийн цуглуулга, 2) Бүлгийн харилцан танин ойлголцол: хэрэв хоёр бүлгийн хүмүүс өөрсдийгөө өөр ард түмнүүд гэж үзэж байвал тэд өөр өөр хэл дээр ярьдаг гэсэн үг (ЮНЕСКО, UIS, 2006).

Олон оронд хүн амын тооллогод хэлний асуудал ордог. НҮБ-ын хүн ам, аж ахуйн тооллогын зарчимд зааснаар хэлний тухай 3 төрлийн баримт байдаг. Эдгээрт:

- а) Төрөлх хэл гэдэг нь бага насандаа гэртээ ярьдаг байсан хэл;
- б) Ярианы хэл гэдэг нь тухайн хүний одоогийн ярьж байгаа буюу голцуу гэр орондоо ярьж буй хэл;
- в) Тооллогын үед нэрлэсэн 1 буюу түүнээс дээш тооны хэлээр ярих чадвар зэрэг юм.

Хэлний тухай баримтууд нь хэлний олон талт шинж байдлын төлөв, чиг хандлага болон төрөлх хэлээрээ ярьдаг хүмүүсийн тоог тодорхойлох боломж олгоно. ЮНЕСКО-д (2003) хэлний амьдрах чадвар, түүнд учирч буй аюулыг дүгнэх арга зүйн дараах 9 үзүүлэлтийг боловсруулсан. Эдгээрт:

- Тухайн хэлээр яригсдын үнэмлэхүй тоо;
- Тухайн хэлээр ярьдаг хүмүүсийн тоог нийт хүн амын тоотой харьцуулсан байдал;
- Тухайн хэлний боловсрол, хэлзүйн материалын хүртээмжтэй байдал;
- Шинэ салбар болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд үзүүлэх хариу үйлдэл;
- Бичиг баримтын төрөл, чанар;
- Хэлний үеэс үед дамжиж ирсэн байдал;
- Ард түмний гишүүдийн төрөлх хэлэндээ хандах хандлага;
- Хэл хэрэглэх салбарын шилжилт өөрчлөлт;
- Харилцаа ба төрийн болон албан ёсны хэлний тухай бодлогыг оруулаад засгийн газар, мэргэжлийн хэлний хандлага, бодлого зэрэг багтана.

⁵Зарим тохиолдолд тоглолтын өөр өөр цаг үед үзэгч, тоглогч нь нэг хүн байж болно.

Энэхүү арга зүйг ашиглан ЮНЕСКО аюулд учраад байгаа хэлнүүдийн жагсаалтыг гарган *Аюулд өртөөд байгаа дэлхийн хэлнүүдийн атласт* тэмдэглэсэн нь биет бус соёлын өв болон өвөрмөц шинж байдлын эх үүсвэрийн устан алга болж буй үзэгдлийг шинжин судлах зорилготой (ЮНЕСКО, 2009b).

Соёлыг таних дадал заншлыг хэмжих нь

Соёлын нийгмийн үзүүлэлтийг хэмжих өөр нэг арга бол соёлын үйл ажиллагааны нийгэм, эдийн засгийн нөлөөг судлан хэмжих юм.

Колумбид “фиеста”-ийн нийгэм, эдийн засаг, соёлын нөлөөг үнэлдэг байна. “Фиеста” буюу “баяр наадам” гэдэг нь “амьдрал, ертөнцийн чиг баримжаа, домог, итгэл үнэмшил зэргийн үлгэр мэт зөн билгийн бүтэц, эдийн засаг, шашин шүтлэг, улс төр болон бусад сэдлүүдтэй холбоотой олон түмний ойлголт гэж тодорхойлж болох юм. Эдгээр нь тодорхой цаг үед, тодорхой орон зайд, тодорхой нийгэмд уламжлалаар дамжих мөн чанартай” (Конвенио АНдрес Белло, 2004). Фиеста-гийн нийгэм, соёлын хэмжилтийг дараах зүйлсийг задлан шинжилснээр хийх боломжтой. Үүнд:

- Нийгмийн оролцоо: олон нийтийн үзэгч-жүжигчдийг фиеста-д идэвхтэй оролцуулах;
- Соёлыг таних: тухайн ард түмний үйл ажиллагаанд оролцох оролцоо (нийгэм, соёлыг таних);
- Соёлын олон төрөл зүйл: фиеста бэлтгэх, зохион байгуулах үеийн янз бүрийн соёлын хандлагын илэрхийллүүд (уламжлалт, угсаатны зүйн, шашны болон уран сайхны илэрхийлэл, тоглоом наадам г.м);
- Нийгмийн нэгдэл; фиеста-г бэлтгэх, зохион байгуулахад оролцох янз бүрийн салбар, уран бүтээлчдийн оролцоо;
- Нийгмийн харьяалал: бүлэг хүмүүс нийгмийн уран бүтээлчид фиеста-г эзэмших эрхээ дамжуулан илэрхийлдэг хувь хүний болоод олон нийтийн хэлбэрүүд зэрэг багтаж байна.

Соёлын бусад нийгмийн хэмжүүрүүд

Соёлоос нийгэм эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг хэмжихэд соёлын болон нийгмийн капиталын үзэл баримтлал тун хэрэгцээтэй байдаг. Дэвид Тросбигийн үзэж байгаагаар “соёлын капиталын биет нь соёлын үнэ цэнийг өөртөө агуулсан ямарваа нэг эдийн засгийн үнэт цэнээс гадна соёлын үнэт зүйлсийн хөрөнгө гэж тодорхойлж болох юм... соёлын өвд авсан барилга нь үл хөдлөх хөрөнгийн хувьд арилжааны үнэ өртөгтэй байх боловч тодорхой бие хүмүүс, олон түмний хувьд түүний үнэ цэнэ нь эн түрүүн гоо сайхан, оюун санаа, бэлгэ тэмдгийн элементүүдэд байх бөгөөд эдийн засгийн аливаа тооцооноос ангид оршино. Эдгээр үнэт чанаруудыг нь соёлын үнэ цэнэ гэж үзнэ. Ийм шинж чанараар тодорхойлогдсон соёлын капитал нь барилга байшин, дурсгалт зүйлс, урлагийн бүтээл, материаллаг соёлын хөшөө дурсгал зэргийн байрлаж буй газар нутаг гэх зэрэг биет хэлбэрээр, мөн санаа сэдэл, ёс заншил, итгэл үнэмшил, уламжлал зэрэг биет бус хэлбэрээр байж болно” (Тросби, 2001).

Хүрээ 2. Уугуул болон уламжлалт мэдлэг

Уламжлалт, орон нутгийн мэдлэг нь уугуул ард түмний мэдлэгтэй байнга холбогддог. Угандачууд уугуул ард түмний мэдлэгийг “уламжлалт болон орон нутгийн мэдлэг нь газарзүйн тодорхой нэг байршилд тухайн нутгийн уугуул бүлгийн хүрээнд тодорхой нөхцөл байдалд оршдог” гэж тайлбарлажээ (Хүйс, Хөдөлмөр, Нийгмийн Хөгжлийн Яам, 2006).

Номхон далайн нийгэмлэгийн хэрэг эрхлэх газраас тодорхойлсноор уламжлалт болон орон нутгийн мэдлэг гэдэг нь “агуулга, чанар, зорилгоос үл хамааран илрэн гарч буй уламжлалт мэдлэгийн илрэх аргыг хэлэх бөгөөд тэдгээр нь биетээр болон биет бусаар оршин байж болох ба дээр дурьдсанаас гадна дараах зүйлсийг багтаана. Үүнд:

- а) нэр ус, өгүүлэл, аялгуу, оньсого, түүх, дуу зэргийн аман хэлбэр;
- б) урлагийн болон гар урлалын эд зүйлс, хөгжмийн зэмсэг, баримал, уран зураг, сийлбэр, вааран эдлэл, наанги шороон зүймэл, модон эдлэл, металл эдлэл, хар зураг, гоёл чимэглэлийн зүйлс, сүлжсэн эдлэл, хатгамал, хясаан зүйлс, хивс, хувцас хунар, бөс бараа ;
- в) дуу хөгжим, бүжиг, театр, уран зохиол, баяр ёслол, зан үйлийн илэрхийлэл, соёлын дадал заншлууд;
- г) хэлбэржсэн дүрс, барилга байгууламж болон визуал байгууламжийн биетүүд, хэсгүүд;
- д) уран барилгын хэв загвар;

Ариун гэгээн нууц гэдэг нь аливаа уламжлалт мэдлэг, нууц болон ариун зүйлсийг агуулан уламжлалт эзэмшигчийн хууль ёс, заншилтай зохицсон уламжлалт мэдлэг ба соёлын мэдлэг буюу илрэл юм.

Уламжлалт мэдлэг нь ерөнхийдөө дараах шинж чанартай:

- а) уламжлалт эдийн засаг, оюун санаа, зан үйл, өгүүлэмж, чимэглэл, зугаа цэнгэлийн зорилгоор бүтээж, эзэмшиж, урамшуулах.
- б) үеэс үед дамжсан;
- в) тодорхой уламжлалт бүлэг, отог омог болон ард түмэнд (тухайн орны) харьяалагддаг гэж тооцогддог;
- г) хамтын бүтээл бөгөөд хамтаар эзэмшдэг зэрэг болно”.

Эх сурвалж: SPC, 2002.

Гонг Конгийн бүтээлч индексэд нийгмийн капиталыг “итгэлцэл, харилцан нөлөөлөл, хамтын ажиллагаа, өргөн хүрээтэй нийгмийн харилцаа холбооны үндсэн дээр... үүсч, хамтын сайн сайхан байдал, нийгмийн амьдралын оролцоо, иргэний идэвхийг дээшлүүлж, хувь хүн болон нийгмийн хөгжил цэцэглэлтэд хүргэх боломжийг бий болгоно” гэж тодорхойлжээ. Энэ нь дараах 9 үзүүлэлтээр хэмжигдэнэ. Үүнд: Ерөнхий итгэлцэл, хууль эрхийн итгэлцэл, харилцан үйлчлэл, ач холбогдолтой байх, хамтын ажиллагаа, цөөнхөд найрсаг хандах, орчин үеийн үнэлэмжийг даах, өөрийгөө илэрхийлэх, нийгмийн амьдралд оролцох зэрэг багтжээ (Соёлын Бодлогын Судалгааны Төв, 2005).

Соёлын зарим нийгмийн элементүүд, тэдгээрийн нийгэмд үзүүлэх нөлөө зэрэг соёлын бусад салбаруудыг уг хамрах хүрээнд багтаахын тулд соёлын бусад үзүүлэлттэй холбоотой ажлыг үргэлжлүүлэх шаардлагатай. *Соёлын болон байгалийн өвийн* салбарт хэсэгчлэн оруулсан соёл, байгаль орчны харилцааг тогтвортой хөгжүүлэхийн тулд асуудлыг цаашдаа улам боловсруулах шаардлагатай. Хурцаар тавигдаж буй бас нэг асуудал нь соёл болон сайн сайхны тухай буюу тухайлбал соёл болон эрүүл мэндийн асуудал юм. Эрүүл мэнд, байгаль орчны хоорондын харилцаа нь өргөн утгаараа соёлын хүрээнээс давж байгаа бөгөөд энд соёл түүний статистикийн бусад салбартай холбогдох асуудлыг хэлэлцэх ёстой. Жишээ нь: Хөгжим тоглох зэрэг соёлын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ерөнхий эрүүл мэндийн байдалд нөлөөлж болзошгүй байдлыг үүнд багтааж болно (Микалос, 2003, 2005).

5. Тоо баримт цуглуулах: Олон улсын ангиллын дүрмийн хүснэгтүүд

Энэ бүлэгт өмнөх хэсэгт тайлбарласан олон улсын ангиллын дүрмийн жагсаалтыг орууллаа. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бараа, үйлчилгээ, ажил эрхлэлт болон дадал заншил зэргийг соёлын салбар бүрээр, соёлын мөчлөгийн хүрээний үүргээр нь тодорхойлсон болно. Гэлээ ч бүх салбарын ангилал болон соёлын мөчлөгийн бүх үе шатыг нэг бүрчлэн тодорхойлох шаардлагагүй юм. Жишээ нь: ЭЗБТҮАСА (эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал), БҮНА (бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал), УС (уялдуулсан систем), ТТҮА (төлбөрийн тэнцэл дэх үйлчилгээний ангилал) зэрэг нь эдийн засагтай уялдаатай ба эдгээр соёлын дүрмүүд нь бүтээн бий болгохоос эхлээд тайлагнан үзүүлэх хүртэлх бүх үе шатыг хамардаг төдийгүй ЦАСҮАОУА-ын оролцоог ч мөн хамруулсан болно.

Ангилал тус бүр зөвхөн ганц удаа дурьдагдана. ЭЗБТҮАСА болон БҮНА харьцааг олох зорилгоор ЭЗБТҮАСА ангилал янз бүрийн салбарууд дээр гарч ирж болно (Хүснэгт 2). Гэхдээ ЭЗБТҮАСА ангиллыг ашиглаж соёлын салбарын хэмжээг тодорхойлоход тэдгээрийг ганц л удаа дурьдагдах ёстой. Налуу хэвээр бичсэн буюу одоор тодруулсан ангиллуудыг соёлын болон соёлын бус гэж ялгаж ангилах үед л хэрэглэнэ.

Хүснэгт 2. БУНА 2, ЭЗБТУАСА 4 ангиллуудаар тодорхойлогдсон соёлын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бараа, үйлчилгээ

СОЁЛЫН САЛБАРУУД					
Салбар	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа ¹			Бараа, үйлчилгээ	
	ЭЗБТУ АСА 4		Тодорхойлолт	БУНА 2	Тодорхойлолт
А. Соёлын болон байгалийн өв	9000		Бүтээлч, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа	38962	Шуудангийн болон тэмдэгт марк, хүчингүй болсон марк, анхны сүлд тэмдэг, захидлын нүүр, дугтуйнууд, шуудангийн хэрэгслүүд (тэмдэгт цаас) болонэдгээртэй төстэй зүйлс; мөн зоос цуглуулах сонирхол эсхүл угсаатны, түүхийн, биений бүтэц зүйн, эрдэс судлалын, ургамлын, экологийн, амьтан судлалын сонирхлыг харуулсан цуглуулгын хэсгүүд
	9102	4	Түүхэн дурсгалт барилга байгууламж, газруудын музей, үзвэрийн үйл ажиллагаа	96411 96412	Түүхэн газар нутаг, барилга байгууламжаас гадна музейн үйлчилгээ Түүхэн дурсгалт газар нутаг, барилга байгууламжийг хамгаалах үйлчилгээ
